

МОНГОЛБАНК



СЭТГҮҮЛЧДЭД ЗОРИУЛСАН ГАРЫН АВЛАГА

(Анхан шатны сургалт)

Олон Нийтийн Боловсрол, Мэдээллийн Төв

Монгол Улс, Улаанбаатар хот, Бага тойруу-3, 15160,

СЭТГҮҮЛЧДЭД ЗОРИУЛСАН ГАРЫН АВЛАГА (Анхан шатны сургалт)

Редактор: Санхүүгийн тогтвортой байдлын ажлын албаны дарга/Ерөнхийлөгчийн зөвлөх:
Ц. Мөнхбаяр

Хянасан:

Ерөнхий эдийн засагч/Ерөнхийлөгчийн зөвлөх: С. Болд
Мөнгөнийн бодлого, судалгааны газар: Б. Лхагважав, Р. Мөнхгэрэл, Х. Саруул.
Валют, эдийн засгийн газар: Б. Цэнгүүнжав, С. Мөнхчимэг, Б. Мөнхзул
Хяналт шалгалтын газар: Ч. Даваажав
Мөнгөн тэмдэгт, үнэт зүйлсийн газар: П. Сүхбаатар, Г. Дуламсүрэн, С. Бүрэнцогт
Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн ажлын алба: С. Мягмарсүрэн
Төлбөр тооцоо, бүртгэлийн газар: Т. Амарсайхан, Х. Батчулуун
Дотоод хяналт, үйл ажиллагааны эрсдлийн газар: Х. Дэлгэр

Эхийг бэлтгэсэн: “Монсудар” хэвлэлийн газар: З.Цэрэндагва

Хэвлэлийн хуудас: 10 х.х

Цаасны хэмжээ: 140 × 140 мм

Хэвлэсэн тоо: 300 ширхэг

Эрхлэн гаргасан: Олон нийтийн боловсрол, мэдээллийн төв

Энэхүү товхимлын зохиогчийн эрх Монголбанкинд хадгалагдана.

“Адмон принт” ХХК–д хэвлэв.

2015 он

ГАРЧИГ

Өмнөтгөл	4
Монголбанкны бүтэц, зохион байгуулалт	6
Монголбанкны товч түүх	7
Мөнгө ба сангийн бодлого	13
Мөнгөний бодлогын хэрэгслүүд ба мөнгөний зах зээл дээрх үйл ажиллагаа	23
Инфляци	35
Засгийн газрын үнэт цаас	51
Ипотекийн зээл гэж юу вэ?	57
Эдийн засгийн мөчлөг	67
Ханшийн бодлогын асуудлууд	71
Төлбөрийн тэнцэл	87
Монголбанкны статистикийг хэрхэн ашиглах вэ?	91
Орчин үеийн банкны эхлэл	105
Санхүүгийн тогтвортой байдал ба макро зохистой бодлого	111
Монгол Улсын төлбөрийн систем	123
Монголбанкны алт худалдан авалт	129
Мөнгөн тэмдэгтийн нууцлал	135
Ном зүй	153
Тэмдэглэл	154

ӨМНӨТГӨЛ

Монгол Улсын эдийн засгийн хэтийн төлөв өөдрөг хэдий ч дунд хугацаанд эдийн засгийн хүндрэлийг зардал багатай даван туулах, тогтвортой, хүртээмжтэй өсөлтийн суурийг тавих сорилт тулгарч байна. Ийм цаг үед эдийн засгийн нөхцөл байдал, үйл явдлын талаарх цаг үеийн, бодитой мэдээлэл нь бодлого боловсруулагч болон олон нийтийн хувьд нэн чухал болж байна.

Бизнес, эдийн засгийн сэтгүүл зүйн салбар нь бусад дэд салбарын нэгэн адил мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэхээс гадна дараах шалтгааны улмаас манай улсын хувьд илүү өндөр ач холбогдолтой байна. Үүнд:

- 1) Монгол Улс нь байгалийн баялаг ихтэй, хөгжиж буй орнуудын нэгэн адил Голланд өвчин нэрвэгдэх, Засгийн газар нь баялгийн орлогыг зөвхөн богино хугацааны зорилгод ашиглаж, урт хугацааны хөгжлийн асуудлыг орхигдуулах, нийгэм, эдийн засгийн тогтворгүй байдал бий болох зэрэг баялгийн хараалд өртөж болзошгүй юм. Энэ сөрөг үзэгдлээс урьдчилан сэргийлэх, болзошгүй эрсдэлийг зөв дүгнэж, олон нийтийн анхаарлын төвд авч ирэн бодлогын шийдвэр гаргагчдад нөлөөлөх боломж, бололцоо, хариуцлага нь бизнес, эдийн засгийн сэтгүүлчдэд байна.
- 2) Аливаа эдийн засгийн бодлогын үр дүн нь зах зээлд оролцогчид уг бодлогыг хэрхэн ойлгож, зөв хариу үйлдэл үзүүлэхээс шалтгаалдаг. Өөрөөр хэлбэл, бизнес, эдийн засгийн сэтгүүлчид энэхүү эдийн засгийн тоо, мэдээлэл, хэрэгжүүлж буй бодлогыг улс орон, өрх гэрийн түвшинд хэрхэн нөлөөлөх, ямар үр дүнд хүрэхийг олон нийтэд хэрхэн зөв, энгийн, оновчтой тайлбарлахаас ихээхэн хамаарч байна.

- 3) Олон нийтийн сүлжээ хүчтэй хөгжсөн энэ цаг үед мэргэжилтний боловсруулсан мэдээллийн ач холбогдол улам нэмэгдэж байна. Ялангуяа нийт иргэдийн 70% нь интернэт хэрэглэж байгаа манай улсын хувьд иргэд өөрсдийн үзэл бодлоо олон нийтийн сүлжээгээр дамжуулан солилцож байгаа нь сайшаалтай хэдий ч зарим тохиолдолд зах зээлд оролцогчид нь хэт нэг талыг барьсан, эх сурвалж тодорхой бус мэдээлэлд үндэслэн шийдвэр гаргах эрсдэл бий болж болзошгүй юм. Ийм нөхцөлд бизнес, эдийн засгийн сэтгүүлчид илүү мэргэжлийн ёс зүй, чадвартай байх шаардлагатай байна.
- 4) Энэ салбар нь эдийн засаг дахь мэдээллийн тэгш бус байдлын гажуудлыг залруулж, эдийн засагт оролцогчдыг зөв шийдвэр гаргахад нь туслах нийтийн барааг үйлдвэрлэгч, түгээгч юм. Энэ ч утгаараа олон улсын түвшинд, ялангуяа санхүү, эдийн засгийн хямралын дараагаас бизнес, эдийн засгийн сэтгүүл зүйн ач холбогдол улам нэмэгдээд байна.

Монголбанкны хувьд дээрх нөхцөл байдал, шаардлагыг харгалзан бизнес, эдийн засгийн чиглэлийн сэтгүүлчдэд эдийн засгийн сургалт, семинарыг сүүлийн жилүүдэд тогтмол зохион байгуулж, хамтран ажиллаж байна. Энэ хүрээнд мөнгө, сангийн бодлого, эдийн засгийн өсөлт, инфляци, валютын ханш, банкны систем, төлбөр тооцооны систем, санхүүгийн тогтвортой байдал зэрэг олон сэдвийг хөндөж, анхан болон дунд түвшинд танилцуулаад байна.

Энэ удаа бид өмнө нь зохион байгуулсан сургалтын материалыг эмхтгэл болгон “Сэтгүүлчдэд зориулсан гарын авлага” –ыг боловсруулан та бүхэнд өргөн барьж байна.

Цаашид энэхүү гарын авлагын агуулга, бүтэц, хүртээмжийг сайжруулан боловсронгуй болгоход Та бүхний санал үнэ, цэнтэй тул саналаа Монголбанкны Олон нийтийн боловсрол, мэдээллийн төвд хаяглан info@mongolbank.mn цахим шуудангийн хаягаар ирүүлнэ үү. Таны саналыг хүлээн авахдаа бид үргэлж таатай байх болно.

МОНГОЛБАНКНЫ БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Монгол Улсын хэмжээнд төрийн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага нь Монголбанк юм. Монголбанкны үндсэн зорилт нь үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгийн тогтвортой байдлыг хангахад оршино. Монголбанк өөрийн үндсэн зорилтын хүрээнд санхүүгийн зах зээл, банкны тогтолцооны тогтвортой байдлыг хангах замаар үндэсний эдийн засгийн тэнцвэртэй хөгжилд дэмжлэг үзүүлдэг бөгөөд Төв банк (Монголбанк)–ны тухай хуульд заасан өөрийн зорилтыг биелүүлэхийн тулд дараах чиглэлээр үйл ажиллагаа эрхэлнэ:

1. Мөнгөн тэмдэгт гүйлгээнд гаргах
2. Мөнгөний бодлого боловсруулж, хэрэгжүүлэх
3. Засгийн газрын санхүүгийн зуучлагчийн үүрэг гүйцэтгэх
4. Банкны үйл ажиллагаанд хяналт тавих
5. Банк хоорондын төлбөр тооцоог зохион байгуулах
6. Гадаад валютын улсын нөөцийг эзэмшиж, удирдах

Монголбанк өдгөө удирдлага (Ерөнхийлөгч, Тэргүүн дэд ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч), есөн газар, бие даасан хоёр алба, нэг төв, орон нутаг дахь Монголбанкны 17 хэлтэс, салбар, гадаад дахь төлөөлөгчийн газартайгаар төрийн мөнгөний бодлогыг хэрэгжүүлж, банкуудын үйл ажиллагааг хянан чиглүүлж байна. Олон улсын түвшинд Монголбанкны хамтын ажиллагаа өргөжиж дэлхийн олон орны Төв банкуудтай ажил хэргийн холбоотой болоод байна.

МОНГОЛБАНКНЫ ТОВЧ ТҮҮХ

1924 оны 6 дугаар сарын 2-нд Орос, Монголын хувь нийлүүлсэн хөрөнгөөр Монголын худалдаа ба аж үйлдвэрийн банк (Монголбанк) байгуулагджээ. Анх нээгдэхдээ 260 мянган янчааны хөрөнгөтэй, 22 орон тоотой, үүний дотор Зөвлөлтийн мэргэжилтэн 18, Монгол ажилчин 4 байжээ. Энэ бол Монголбанкны суурь тавигдсан түүхт үйл явдал байв.

1920-иод онд мөнгөний шинэчлэлт хийж, Монголын үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгийг гүйлгээнд гаргаж, худалдаа бэлтгэлийн ажиллагааг санхүүжүүлж, зах зээлийн барааны хангамж, үнийн хөдөлгөөнийг зохицуулж, ардын аж ахуйтанд зээл олгож байсан нь Монголбанкны үндсэн үйл ажиллагаа болж байлаа. Тэр үед Монголбанкны бүх ажилчдын 20 хүрэхгүй хувийг Монголчууд бүрдүүлж байсан тоо баримт бий.

1924–1955 он хүртэл В.И.Комар, Д.И. Микилман, Н.И. Дойчман, С. Довчин, Ю.Цэдэнбал болон Т. Балдан нар нь Монголын Худалдаа ба аж үйлдвэрийн банк (Монголбанк)–ны даргын албан тушаалыг хашиж байсан.

1950-иад он гэхэд Монголбанкны аппарат өргөжин бэхжиж бүх аймаг, томоохон хот сууринд өөрийн салбартай болж, ЗХУ-ын мэргэжилтнүүдийн ачаар үндэсний боловсон хүчин бэлтгэгдэж нийт ажилчдын 98 хувийг эзлэх болов. ЗХУ Монголбанкинд оруулсан өөрийн хувь хөрөнгө, хувьцааг 1954 онд Монголын талд шилжүүлэн өгсөнөөр Монголбанк нь Улсын банкны Ерөнхий хороо болон зохион байгуулагджээ.

1955–1991 он хүртэл Улсын банкны Ерөнхий хороон даргын албан тушаалыг Г.Балжид, Л.Лхамсүрэн, П.Төмөр, Д.Данзан, Г.Хүдэрчулуун нар хашиж байсан бөгөөд энэ хугацаанд 400 гаруй санхүү банкны тэргүүний ажилтан төржээ.

Улс төр, нийгэм, эдийн засагт шинэчлэл хийгдэж 1990 онд “Аж ахуйн банк байгуулах болон түүний үйл ажиллагааны нийтлэг дүрэм”, 1991 онд Банкны тухай хууль батлагдсанаар Монгол Улсад хоёр шатлалт банкны тогтолцооны хөрс суурь тавигджээ.

Банкны хоёр шатлалтай тогтолцоонд шилжсэнээс хойш өдгөөг хүртэл 31 банк байгуулагдаж, үйл ажиллагаа явуулснаас 17 банк нь өөрийн үйл ажиллагааны алдаанаас шалтгаалан санхүү, төлбөрийн чадваргүй болон дампуурч, дүрмийн санг тогтоосон хэмжээнд хүргээгүй, бусад банктай нэгдэх, татан буугдах зэргээр үйл ажиллагаагаа зогсоож Монголбанкнаас олгосон тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон байна.

1991–2012 он хүртэл шилжилтийн хүнд хэцүү үед Монголбанкийг толгойлох, хоёр шатлалтай банкны тогтолцоог бэхжүүлэх хүндхэн үүрэг хариуцлага Н.Жаргалсайхан,



Д.Моломжамц, Ж.Үнэнбат, О.Чулуунбат, А.Батсүх, Л.Пүрэвдорж нарт оногдож байжээ. Тэд банкны салбарын тогтвортой байдлыг хангах, мөнгөний нийлүүлэлтийг зохистой түвшинд барих, төгрөгийн ханшийг хамгаалах, инфляцийн түвшинг тууштай бууруулах, эдийн засгийн өсөлтийг дэмжих талд анхаарал тавин, хүчин чармайлт гарган ажиллаж байв.

2012 оноос Монголбанкны Ерөнхийлөгчөөр Н.Золжаргал нь томилогдон ажиллаж байна.

2014 оны байдлаар нийт 14 банк үйл ажиллагаагаа явуулж байна. Тус банкны 1484 салбар, нэгжээр дамжуулан Монгол Улсын бүх аймаг, хот, сум, суурин газруудад



үйлчилж байгаа бөгөөд тэдгээрт 15227 ажиллагсад ажиллаж манай улсын аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд банкны үйлчилгээг хүргэж байна.



Төв аймгийн Алтанбулаг сум, Монголбанкны барилга, 1934 он

ОН ЦАГИЙН ХЭЛХЭЭС (МОНГОЛБАНК)

- 1260 – Их Юань Улс байгуулагдсанаар Манай улс дэлхийд анх удаа цаасан дэвсгэрт гүйлгээнд гаргасан
- 1924 – Орос Монголын хувь нийлүүлсэн Худалдаа ба аж үйлдвэрийн банк (Монголбанк) байгуулагдсан
- 1925 – Үндэсний валютыг төгрөгөөр тогтоосон
- 1926 – Цагаан мөнгөн зоос анх гүйлгээнд гаргасан
- 1931 – Урт хугацаатай зээл өгч эхэлсэн
- 1940 – Улсын төсөв Монголбанкаар дамжих болсон
- 1946 – Зээлийн барьцаа эхэлсэн
- 1954 – ЗХУ Монголбанкинд оруулсан өөрийн хувь хөрөнгө, хувьцааг Монголын талд шилжүүлэн өгсөнөөр Монголбанк нь Улсын банкны Ерөнхий хороо болон зохион байгуулагджээ.
- 1963 – Монгол Улс олон талт бүртгэл тооцооны системд шилжсэн
- 1991 – Банкны тухай хууль батлагдав
- 1992 – Банк хоорондын Клирингийн тогтолцоо эхэлсэн
- 1993 – Монголбанк Банкны хяналт шалгалтын ерөнхий чиглэлийг баталсан
- 1994 – Нягтлан бодох бүртгэлийн шинэ тогтолцоог хэрэгжүүлж эхэлсэн
- 1996 – 1993 оноос эхтэй банкуудын хямрал болж Ард, Даатгал зэрэг банкууд татан буугдсан

- 2001– Монголбанкны дүрмийн санг “нэг тэрбум” төгрөгөөс доошгүй байх гэсэн хэмжээг “дөрвөн тэрбум төгрөг” болгов
- 2002 – Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны тухай хууль батлагдав
- 2002 – Үнэт цаасны зах зээлийн тухай хууль батлагдав
- 2006 – Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль батлагдав
- 2008 – Банкин дахь мөнгөн хадгаламжинд баталгаа гаргах тухай хууль батлагдав
- 2009 – Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хууль батлагдав
- 2011– Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хууль батлагдав
- 2011– Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг 16 тэрбум төгрөг байхаар тогтоов
- 2012 – “Зээлийн батлан даалтын сангийн тухай” хууль батлагдав
- 2012 – Монгол Улсын Засгийн газар, Монголбанкны хооронд “Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дунд хугацааны хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэх харилцан ойлголцлын санамж бичиг” байгуулав
- 2013 – Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль батлагдав
- 2014 – Засгийн газрын 121 тоот тогтоолоор Банкны салбарын ажилтны өдрийг жил бүрийн 06 дугаар сарын 02–ны өдөр тэмдэглэдэг болсон
- 2015 – Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг 16 тэрбумаас 50 тэрбум төгрөг байхаар шинэчлэн тогтоов

СЭДЭВ 1:

МӨНГӨ БА
САНГИЙН
БОДЛОГО


ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН ТӨРЛҮҮД

1. Тогтворжуулах бодлого (Stabilization Policy) = Macroeconomic Policy

- Төсвийн бодлого (Fiscal Policy)
- Мөнгөний бодлого (Monetary Policy)


2. Бүтцийн бодлого (Structural Policy)

Макро эдийн засгийн бодлого нь эдийн засгийн гадаад, дотоод тэнцвэрийг хангахад чиглэх бөгөөд мөнгөний болон төсвийн бодлогоор дамжин хэрэгжиж, эдийн засаг дахь нийт эрэлтэд нөлөөлөх замаар харьцангуй богино хугацаанд макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах зорилтоо биелүүлдэг.



ТӨСӨВ, МӨНГӨНИЙ БОДЛОГЫН УЯЛДАА


Мөнгөний бодлого нь 1980 он хүртэл сангийн бодлогын хавсарга байдалтай явж ирсэн. Түүнээс хойш тодорхой дүрэмд суурилсан төсвийн бодлого, инфляцийн онилох бие даасан мөнгөний бодлогыг хөгжингүй орнууд хэрэгжүүлж эхэлсэн. Төсөв, мөнгөний бодлогын уялдаа нь тухайн орны санхүүгийн салбарын гүнзгийрэлт, ханшийн дэглэм, институцийн бүтэц зэрэг онцлог шинжээс хамаардаг. Төсвийн бодлого нь урт хугацааны тогтвортой байдалд чиглэх ёстой бөгөөд мөнгөний бодлого нь үнийн тогтвортой байдлыг хангах үндсэн зорилтынхоо хүрээнд макро эдийн засгийн болоод санхүүгийн тогтвортой байдлыг хангахад чиглэгддэг.



МӨНГӨНИЙ БОДЛОГО ГЭЖ ЮУ ВЭ?

Мөнгөөр дамжуулан эдийн засгийн байдал буюу эдийн засгийн өсөлт, үнэ, төлбөрийн тэнцэл, ажилгүйдэл гэх зэрэг макро эдийн засгийн орчинд нөлөөлөх Төв банкны үйл ажиллагааг мөнгөний бодлого гэнэ.

Мөнгөний бодлого улс орны эдийн засгийн хөгжлийг удирдах макро эдийн засгийн бодлогын нэг хэсэг бөгөөд Засгийн газрын шууд нөлөөллөөс тусдаа байж зах зээлийн механизмд суурилан хэрэгждэг онцлогтой.



ТӨВ БАНКНЫ ҮНДСЭН ЗОРИЛГО

Аливаа орны Төв банкны үндсэн зорилго нь үнийн тогтвортой байдлыг (инфляци) хангах юм.

Төв банк нь өөрийн үндсэн зорилтын хүрээнд санхүүгийн зах зээл, банкны тогтолцооны тогтвортой байдлыг хангах замаар үндэсний эдийн засгийн тэнцвэртэй хөгжилд дэмжлэг үзүүлдэг.


Төв банк нь төрийн мөнгөний бодлогыг өөрийн мөнгөний нийлүүлэлтэнд тавих хяналтын үүргээрээ дамжуулан хэрэгжүүлдэг. Учир нь Төв банкны зорилтыг хэрэгжүүлэх болон эдийн засгийн тогтворжилтонд нөлөөлөх гол хүчин зүйл нь мөнгөний нийлүүлэлт болдог.



МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТЭНД НӨЛӨӨЛӨХ БОДЛОГО

Төв банк нь мөнгөний нийлүүлэлтэд нөлөөлөхдөө хуулиар зөвшөөрөгдсөн арга хэрэгслүүдийг ашигладаг.

Мөнгөний бодлого явуулах нь төрөөс баримталж байгаа мөнгөний бодлогын талаарх үндсэн чиглэл зорилгоос шалтгаалдаг. Үүнтэй холбоотойгоор Төв банк нь мөнгөний ХАТУУ болон ЗӨӨЛӨН бодлогын аль нэгийг сонгон хэрэгжүүлдэг.



МӨНГӨНИЙ ХАТУУ, ЗӨӨЛӨН БОДЛОГО

Мөнгөний зөөлөн бодлого:

Эдийн засгийн уналтын үед ажилгүйдлийг бууруулж, эдийн засгийн өсөлтийг эрчимжүүлэх зорилгоор мөнгөний нийлүүлэлтийг өсгөн, мөнгөний зөөлөн бодлогыг авч хэрэгжүүлдэг. (Жишээ нь: Бодлогын хүүг бууруулах)

Мөнгөний хатуу бодлого:


Эдийн засгийн мөчлөгийн сэргэлтийн болон оргил үед үнийн ерөнхий түвшний өсөлтийг бууруулах, урьдчилан сэргийлэх, мөнгөний нийлүүлэлтийг бууруулах зорилгоор мөнгөний хатуу бодлогыг авч хэрэгжүүлдэг. (Жишээ нь: Бодлогын хүүг өсгөх)



Мөнгөний бодлогын зорилтод хүрэх нь


Мөнгөний бодлогын үйл ажиллагаа нь мөнгөний бодлогын шилжих механизмаар дамжин эцсийн зорилгодоо хүрч хэрэгждэг. Өөрөөр хэлбэл, мөнгөний бодлогын хэрэгсэлд гарсан өөрчлөлт нь ямар сувгуудаар дамжин бодлогын эцсийн зорилгодоо нөлөөлж байгааг мөнгөний бодлогын шилжих механизм илэрхийлнэ.

Бодлогын хэрэгсэлд гарсан өөрчлөлт нь үйл ажиллагааны зорилтоор дамжин банкны болон санхүүгийн зах зээлийн хүүний түвшин, (ипотекийн болон хадгаламжийн), олон нийтийн эдийн засгийн хэтийн төлөвийн талаархи хүлээлт, хөрөнгийн үнэ, валютын ханш; улмаар хувь хүн болон пүүсийн зардал, хадгаламж болон хөрөнгө оруулалтын үйл хөдлөлд нөлөөлдөг.



САНГИЙН БОДЛОГО ГЭЖ ЮУ ВЭ?

Макро эдийн засгийн үндсэн зорилтууд болох урт хугацааны эдийн засгийн тогтвортой өсөлтийг бий болгох, инфляцийг тогтворжуулах болон ажилгүйдлийг бууруулах зэрэг эдийн засгийн хөгжлийн тулгуур асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэсэн төрийн үйл ажиллагааг “Сангийн бодлого” гэнэ.



САНГИЙН БОДЛОГЫН АНГИЛАЛ

Сангийн бодлогыг зорилтот ба зорилтот бус гэж хоёр ангилж үздэг.

Зорилтот сангийн бодлого (дискрет): Засгийн газраас урт хугацааны эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах, инфляцийг тогтворжуулах, ажлын байр бий болгох зорилгоор нийт эрэлт буюу төлөвлөгдсөн зардалд сангийн бодлогын арга хэрэгслүүдээрээ дамжуулан зориудаар нөлөөлж байгаа хэлбэр юм. Дискрет сангийн бодлогыг Сангийн тэлэх бодлого, Сангийн хумих бодлого гэж хоёр ангилна.

Зорилтот бус сангийн бодлого (дискрет бус): Засгийн газраас тухайн хугацааны макро эдийн засгийн тогтворжилтыг хангах үүднээс зориудаар нийт эрэлтэд нөлөөлөх бодлого авч хэрэгжүүлээгүй байхад эдийн засгийн нөхцөл байдлаасаа хамааран сангийн бодлогын арга хэрэгслүүд өөрчлөгдөж байх хэлбэр юм.

САНГИЙН БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭРЭГСЭЛ

- Засгийн газрын зардал (Төсөв)
- Татвар
- Шилжих төлбөр зэргээр дамжуулан хэрэгжүүлдэг.

САНГИЙН ТЭЛЭХ БА ХУМИХ БОДЛОГО

Сангийн дискрет бодлогыг хоёр ангилна.

Сангийн тэлэх бодлого

- Сангийн тэлэх бодлогыг ихэвчлэн ажилгүйдлийг бууруулах зорилгоор хэрэгжүүлдэг. (Засгийн газрын зардлыг өсгөх, татварыг бууруулах)

Сангийн хумих бодлого

- Инфляцийг бууруулахад чиглэгддэг (Засгийн газрын зардлыг бууруулах, татварыг өсгөх)

СЭДЭВ 2:

МӨНГӨНИЙ БОДЛОГЫН
ХЭРЭГСЛҮҮД БА
МӨНГӨНИЙ ЗАХ ЗЭЭЛ
ДЭЭРХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ХЭРЭГСЛҮҮД


Төв банк нь мөнгөний бодлогын зорилготой уялдуулан мөнгөний бодлогын олон арга хэрэгслийг ашигладаг. Мөнгөний бодлогын арга хэрэгслийг мөнгөний нийлүүлэлтэд нөлөөлөх байдлаар нь шууд ба шууд бус арга гэж ангилна.

Шууд аргад арилжааны банкны зээлийн үлдэгдэлд хязгаарлалт тогтоох, хүүгийн түвшин өөрчлөх зэрэг аргууд орох бөгөөд мөнгөний нийлүүлэлтийг богино хугацаанд багасгах зорилго тавьсан үед хэрэглэдэг.

Шууд бус аргад:

- **Заавал байлгах нөөцийн хэмжээ** (Арилжааны банкуудын бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгөөсөө бэлэн нөөц хэлбэрээр байлгавал зохих хамгийн доод хэмжээг заавал байлгах нөөц гэнэ. Заавал байлгах нөөц нь мөнгөний нийлүүлэлт буюу эдийн засаг дахь мөнгөний хэмжээтэй урвуу хамааралтай үзүүлэлт юм.)
- **Нээлттэй захын арилжаа** (Банкны нөөцийг удирдах зорилгоор Төв банкнаас нэг жил хүртэл хугацаатай үнэт цаас гаргах, түүнийг худалдах болон худалдан авах,


Эндүүрэл буюу зардлын суваг:



засгийн газрын өрийн бичиг болоод Төв банкнаас хүлээн зөвшөөрөгдсөн бусад үнэт цаасыг мөнгөний зах зээл дээр худалдах, худалдан авах үйл ажиллагааг нээлттэй захын арилжаа гэнэ.)

- **Хүүгийн нэгдсэн бодлого** (Төв банк нь өөрийн үнэт цаасны хүүгээр дамжуулан Засгийн газар болон арилжааны банкуудын зээл, хадгаламжийн хүүд нөлөөлөх замаар мөнгөний нийлүүлэлтийг хянах аргыг хүүгийн нэгдсэн бодлого гэнэ.)
- **Төв банкны зээлжүүлэлт** (Төв банк нь мөнгөний нийлүүлэлтийг зохицуулахдаа заавал байлгах нөөцийн аргаас гадна арилжааны банк болон Засгийн газарт олгох зээлийн хэмжээнд тодорхой хяналт тогтоосноор өөрийн зорилтыг хэрэгжүүлдэг. Өөрөөр хэлбэл зээлээр зохицуулалт хийх ерөнхий аргыг мөн ашигладаг.) гэх мэт аргууд орно.





1. НЭЭЛТТЭЙ ЗАХ ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ГЭДЭГ НЬ

Нээлттэй захын үйл ажиллагаа буюу Төв банкны үнэт цаас (ТБҮЦ)-ны арилжаа нь Монголбанкны мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх үндсэн арга хэрэгсэл юм.

Банк хоорондын зах (БХЗ)-ын богино хугацаат хүү болон нөөц (liquidity)-ийн хэлбэлзлийг удирдах зорилгоор хугацаа (maturity), хүү, арилжаалагдах хэлбэрээр харилцан адилгүй дараах ТБҮЦ-ыг Монголбанк арилжааны банкуудад арилжаалдаг.

Зорилго:

Банк хоорондын захын (БХЗ) тэнцвэрт байдлыг хадгалах;

БХЗ-ын хүүний хэлбэлзлийг бууруулах;

БХЗ-ын хүүний зорилтот түвшинг хадгалах ;

Төв банкны үнэт цаасны төрөл:

Хугацаагаар нь 1 долоо хоногтой, 4 долоо хоногтой гэж ангилна. Нэг долоо хоногийн хугацаатай Төв банкны үнэт цаасны хүүг бодлогын хүү гэнэ.

НЭГ ДОЛОО ХОНОГИЙН ХУГАЦААТАЙ ТБҮЦ

Нэг долоо хоногийн хугацаатай ТБҮЦ нь банкуудын нөөцийг удирдахад чухал үүрэг гүйцэтгэх бөгөөд Монголбанкны мөнгөний бодлогын үндсэн хэрэгсэл юм. Энэ төрлийн үнэт цаасны хүү нь Монголбанкны бодлогын хүү болох бөгөөд БХЗ дээр хөтөч хүүний үүргийг гүйцэтгэдэг.

Анх тогтмол хүүтэй, борлогдох хэмжээ нь хязгаарлалтгүй байсан энэхүү үнэт цаасыг 2007 оны 7 дугаар сард анх нэвтрүүлж 7 хоног бүрийн Лхагва гарагт БХЗ дээр арилжаалах болсон. Энэ төрлийн үнэт цаас нь банкуудад илүүдэл нөөцөө богино хугацаатай хүү өгдөг активт чөлөөтэй байршуулах боломж олгосон бөгөөд уг бүтээгдэхүүн нэвтэрснээр банкуудын нөөцийн удирдлагад мэдэгдэхүйц өөрчлөлт гарчээ.

Тус ТБҮЦ-ны арилжаа нь дараах 4 хэлбэрээр явагдах боломжтой. Үүнд:


- Тогтмол хүүтэй, хэмжээ хязгаарлахгүй арилжаа
- Тогтмол хүүтэй, хэмжээ хязгаарласан арилжаа
- Тодорхой интервалд хүүгээр өрсөлдөх арилжаа
- Хүүгийн дээд хязгаартай, хэмжээ хязгаарлахгүй арилжаа

Давтамж:

Даваа, Лхагва, Баасан гараг бүр 09.30–11.00 цагийн хооронд

Мөнгөний бодлогын хүүний дохио

- Бодлогын хүү ← 1 долоо хоногтой гаргасан ТБҮЦ,



Эх сурвалж: Монголбанк

ДӨРВӨН ДОЛОО ХОНОГТОЙ ТӨВ БАНКНЫ ҮНЭТ ЦААС

Харьцангуй урт хугацаатай санхүүгийн хэрэгслийг мөнгөний зах дээр бий болгох угтвар нөхцөлийг бүрдүүлэх үүднээс Монголбанк 2013 оны 3 дугаар сард дөрвөн долоо хоногийн хугацаатай ТБҮЦ–ыг нэвтрүүлсэн.

Санхүүгийн зах зээлийн зөв зохистой өгөөжийн муруйг бий болгохын тулд Төв банк өгөөжийн муруйн зөвхөн эхний хэсгийг, харин муруйн үлдсэн хэсгийг зах өөрөө тодорхойлж байх ёстой. Иймээс Монголбанк 7 хоногийн ТБҮЦ–ны хүүгээр дамжуулан зөвхөн богино хугацааны хүүнд нөлөөлөхийг оролддог бол дөрвөн долоо хоногийн хугацаатай ТБҮЦ–ны хүү нь ирээдүйн арилжаа, эрсдэлийн болон нөөцийн үнийн хүлээлт зэрэг хүчин зүйлстэй уялдаж, БХЗ дээр тодорхойлогддог байна.

Монголбанк энэ төрлийн үнэт цаасыг дөрвөн долоо хоногийн давтамжтайгаар БХЗ дээр тогтмол арилжаалж байна. Тус арилжааг хүүний дээд хязгаар (репо санхүүжилтийн хүү буюу бодлогын хүүн дээр нэмэх нь 0.5 нэгж хувь)–тай, урьдчилж зарласан хэмжээн дээр банкууд хүүгээр өрсөлдөх зарчмаар явуулдаг.

Хүүний дээд хязгаар нь ТБҮЦ болон репо арилжааны хооронд үүсч болох арбитражийг хаах зорилготой юм.

Зарчим

- Хүүгээр өрсөлдөх, хэмжээ зарласан/зарлаагүй

Давтамж

- дөрвөн долоо хоногт нэг удаа.

Зохицуулагдах журам:

- “Төв банкны үнэт цаас арилжааны журам”



2. ТӨВ БАНКНЫ САНХҮҮЖИЛТ

Төв банкны санхүүжилт нь БХЗ–ын нөөцийн түр зуурын дутагдлыг арилгах, илүүдэл нөөцийг шингээх зорилготой.

Төв банкны санхүүжилтийн төрөл

- Өдрийн зээл
- Овернайт репо санхүүжилт
- Овернайт хадгаламж

Өдрийн зээл	Зорилго: Мөнгөний бодлогын зорилгоор бус зөвхөн төлбөр тооцооны хэвийн үйл ажиллагааг хангах Давтамж: Өдөр бүр нээлттэй Хугацаа: Өдөртөө буцаан төлөгдөнө Хүү: Хүүгүй
Овернайт хадгаламж	Зорилго: Хүүний коридорын доод хязгаарыг тогтоох, өдрийн төгсгөлд банкуудын илүүдэл нөөцийг шингээх Давтамж: Өдөр бүр нээлттэй Хугацаа: “Банксүлжээ” систем хаахаас дараагийн өдрийн “банксүлжээ” систем нээх хүртэл үргэлжилнэ. Хүү: Овернайт хадгаламжийн хүү= Бодлогын хүү–2 нэгж хувь

Овернайт репо санхүүжилт	Зорилго: Төлбөр тооцоо гүйцэтгэх мөнгөн хөрөнгө дутагдсан тохиолдолд дутагдлыг арилгах Давтамж: Өдөр бүр нээлттэй Хугацаа: “Банксүлжээ” систем хаахаас дараагийн өдрийн “банксүлжээ” систем нээх хүртэл үргэлжилнэ. Барьцаа хөрөнгө: Төв банкны үнэт цаас Хүү: Овернайт репо санхүүжилтийн хүү = Бодлогын хүү + 2 нэгж хувь
---------------------------------	---

3. МӨНГӨНИЙ БОДЛОГЫН БУСАД ХЭРЭГСЛҮҮД

Заавал байлгах нөөц	Зорилго: Мөнгөний нийлүүлэлтийг хянах, банкны төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг зохицуулах Хугацаа: 14 хоног тутамд (дундаж үлдэгдэл) Хувь: 12%
Барьцаат зээл	Зорилго: Банкууд хүсэлт гаргасан тохиолдолд Төв банкнаас санхүүжилт олгох Хугацаа: 90 хүртэл хоног (Шаардлагатай үед олгогдоно) Барьцаа хөрөнгө: Төв банкны үнэт цаас, Засгийн газрын үнэт цаас, Хөгжлийн банкны вексель, Банкны хэвийн зээл
Своп/Форвард хэлцлүүд	Зорилго: Ханшийн эрсдэлээс хамгаалах, төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хангахад дэмжлэг үзүүлэх Давтамж: Тогтмол бус Своп: Тухайн өдрийн ханш → Ирээдүйд тохиролцсон ханш Форвард: Өнөөдөр үнэ тохирно → Ирээдүйд гүйлгээ хийнэ. Хугацаа: ТБҮЦ болон богино хугацааны ЗГҮЦ–ны хугацаанаас хэтрэхгүй

ХҮҮНИЙ КОРИДОР ГЭЖ ЮУ ВЭ?

Банк хоорондын захын хүүний хэлбэлзэх мужийг тодорхойлдог Төв банкны хэрэгсэл юм.

Хүүний коридорыг нэвтрүүлж, мөнгөний бодлогын хэрэгслүүдийг боловсронгуй болгосноор богино хугацаат хүүг илүү үр дүнтэй удирдан хэлбэлзлийг нь бууруулах, хүүний сувгийн нөлөөллийг сайжруулах, мөнгөний бодлогын хэрэгжилтийн ил тод байдлыг нэмэгдүүлэх зэрэг олон талын ач холбогдолтой.

Хүүний коридорын өргөн нь Монголбанкны бодлогын хүүнээс ± 2 нэгж хувь байх бөгөөд коридорын дээд хязгаарыг овернайт репо санхүүжилтийн хүү (бодлогын хүү + 2

нэгж хувь), харин доод хязгаарыг овернайт хадгаламжийн хүү (бодлогын хүү - 2 нэгж хувь) тус тус тодорхойлно. Бодлогын уг арга хэмжээг хэрэгжүүлснээр банк хоорондын зах илүү үр ашигтай ажиллах, Төв банкны үнэт цаасны хэмжээ буурах суурь нөхцөл бүрдэх юм. .




Эх сурвалж: Монголбанк

СЭДЭВ 3:

ИНФЛЯЦИ

ИНФЛЯЦИ ГЭЖ ЮУ ВЭ?

Инфляци нь хэрэглээний сагсыг бүрдүүлж буй бараа үйлчилгээний үнийн ерөнхий түвшин өсөхийг хэлэх бөгөөд хийлэх, томрох гэсэн утгатай үг юм.



Тухайн жилийн үнийн түвшинг 'P1', өмнөх жилийнх үнийн түвшинг 'P0' гэвэл тухайн жилийн инфляци:

$$(P1 - P0) / P0 \times 100$$

1 ширхэг талхны үнэ = 1 кг төмсний үнэ = 1000₮ гэж үзье.

1 ширхэг талхаар 1 кг төмс авч болно.

Талхны үнэ хэвээрээ 1000₮ байхад төмсний үнэ өсч 2000₮ болбол:


1 ш талх–аар 1/2 кг төмс авах болно.

Энэ нь инфляци биш боловч харьцангуй үнүүдийн өөрчлөлт юм.

Үнийн өсөлт нэгдүгээрт, маш олон бараа үйлчилгээн дээр ажиглагдаж байгаа бол, хоёрдугаарт, тасралтгүй ужигрсан шинжтэй байгаа бол инфляци хэмээн тодорхойлогдоно. Харин нэг удаагийн үнийн өсөлт, эсвэл цөөн бараан дээр ажиглагдах харьцангуй үнийн өсөлт бол инфляци биш юм.

Эдийн засаг дахь үнийн ерөнхий түвшин тогтвортой үед нийгмийн зүгээс зарим нэг барааг илүүд хүсэмжилж болно. Энэ нь тухайн барааны эрэлтийг, улмаар үнийг өсгөнө. Тэрхүү барааг үйлдвэрлэлд хүртэх ашиг нэмэгдэх тул бизнесмэнүүд нөөцөө тэр барааг үйлдвэрлэхэд чиглүүлнэ. Улмаар нийлүүлэлт нэмэгдэн үнэ нь эргээд буурах нөхцөл болдог. Ийм учраас харьцангуй үнийн өсөлт бол эерэг үр дагавартай, зах зээлийн нөөцийг зөв оновчтой хуваарилахад шийдвэрлэх үүрэг гүйцэтгэдэг байна.

Инфляци өслөө гэдгийг зөвхөн барааны үнэ өслөө гэж ойлгож болохгүй юм. Бодит амьдрал дээр тухайн барааны чанар нь, үйлчилгээ нь сайжирсаны улмаас үнэ нэмэгдэж байдаг. Иймээс инфляцийн түвшин өссөн тохиолдол бүрт эдийн засаг буруу ажиллаад байна гэж дүгнэж болохгүй юм.



Жин гэдэг нь өрхийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нийт зардалд тухайлсан бараа, үйлчилгээний зардлын эзлэх хувь хэмжээ юм.

Бага жинтэй барааны үнэ огцом нэмэгдсэн ч инфляцийн түвшинд төдийлөн нөлөөлдөггүй бол жин дардаг барааны үнийн хөдөлгөөн инфляцийн өөрчлөлтийн дийлэнхийг тодорхойлж байдаг.

Инфляцийн бүтцийн тооцоог оны эхнээс тооцсон инфляци дээр суурилан гүйцэтгэдэг.

	Ерөнхий индекс	100.0%
1	Хүнсний бараа, согтууруулах бус ундаа	30.0%
2	Согтууруулах ундаа, тамхи	3.7%
3	Хувцас, бөс бараа, гутал	12.2%
4	Орон сууц, ус, цахилгаан, түлш	14.1%
5	Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	3.5%
6	Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	3.0%
7	Тээвэр	12.6%
8	Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	4.4%
9	Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	3.1%
10	Боловсролын үйлчилгээ	6.1%
11	ЗБ, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	3.5%
12	Бусад бараа үйлчилгээ	3.8%

Эх сурвалж: УСХ

ИНФЛЯЦИЙГ ТӨВ БАНК ТООЦДОГ УУ, ҮСХ-НООС ТООЦДОГ УУ?




Үнийн албан ёсны тоо мэдээллийг зөвхөн Үндэсний статистикийн хороо гаргах эрх, үүрэгтэй. Харин Монголбанк Үндэсний статистикийн хорооноос гаргасан албан ёсны мэдээлэлд тулгуурлан суурь инфляци гэсэн үзүүлэлтийг тооцон гаргадаг. Дэлхийн Төв банкууд мөнгөний бодлогоо боловсруулахдаа суурь инфляци гэсэн үзүүлэлтийг түгээмэл хэрэглэдэг.

ИНФЛЯЦИ 3.4 ХУВИАР ӨСЛӨӨ, 1.9 ХУВИАР ӨСЛӨӨ ГЭЖ ЯНЗ ЯНЗААР ЯРИХ ЮМ. ҮҮНИЙГ ЮУ ГЭЖ ОЙЛГОХ ВЭ?

Үнийг ямар цаг хугацааны үеэр авч үзэж байгаагаас шалтгаалан сарын, оны эхнээс, жилийн өөрчлөлт гэж авч үздэг.

Сарын инфляци гэдэг нь өмнөх сараас үнэ хэдэн хувиар өссөнийг харуулна. Оны эхнээс гэвэл 1 дүгээр сарын 1-нээс хойш үнэ хэдэн хувиар өссөнийг харуулна. Харин жилийн инфляци гэдэг нь үнэ өмнөх оны мөн үеэс хэдэн хувиар өссөнийг харуулах үзүүлэлт юм.

Оны эцэст оны эхнээс тооцсон инфляци, жилийн инфляци хоёр хоорондоо дүйж нэг үзүүлэлт болно. Инфляцийг ҮСХ-ноос нийт улс орны болон Улаанбаатар хотын хэмжээнд тооцон нийтэд зарладаг.



Эх сурвалж: ҮСХ

ИНФЛЯЦИАС ӨӨР ҮНИЙН ХЭМЖҮҮР БАЙХ УУ?

Бидний ярьж хэвшсэн инфляци бол үнийн хэмжүүрийн зөвхөн нэг үзүүлэлт юм.

Үүнээс гадна үйлдвэрлэгчийн үнийн индекс, импортын барааны үнийн индекс, экспортын барааны үнийн индекс, орон сууцны үнийн индекс, дотоодын нийт бүтээгдэхүүний дефлятор гээд үнийг хэмждэг олон үзүүлэлт бий. Тухайлбал, Дотоодын нийт бүтээгдэхүүний дефлятор нь мөн эдийн засаг дахь үнийн ерөнхий түвшинг хэмжих ба түүний ХҮИ–ээс ялгагдах тал нь зөвхөн хэрэглэсэн төдийгүй, үйлдвэрлэсэн бүх бараа үйлчилгээний өртгийг хамруулдагт оршино.

Иймд импортын бүтээгдэхүүнийг борлуулах хэмжээ нь ХҮИ–д нөлөөлөх ба ДНБ–ий дефляторт нөлөөлөхгүй.

ИНФЛЯЦИЙГ ХЭРХЭН АНГИЛДАГ ВЭ?

Инфляци нь хурд, хамрах хүрээ, цаг үе, шалтгаан, хүлээгдэж байсан/үгүй зэргээс нь хамаарч олон янз байна.

Шалтгаанаар нь:

Дефляци–Бүтээгдэхүүн үйлчилгээний үнийн ерөнхий түвшинд үргэлжлэн буурах үзэгдэл юм. Инфляцийн түвшин тэг хувиас доогуур (хасах инфляци) болох үед тохиолдоно. Инфляцийн хурдац буурах үзэгдэл (дисинфляци)–тэй андуурч болохгүй.

- Эрэлтийн инфляци–Нийт эрэлтийн түвшин өссөнөөс үүсэх инфляцийг хэлнэ.



- Зардлын инфляци–Нийт нийлүүлэлтийн өөрчлөлтөөс үүсдэг инфляцийг хэлнэ. Нийлүүлэлтийн механизм алдагдах, хүчин зүйлсийн үнэ өсөх зэрэг хүчин зүйлээс хамааран нийт нийлүүлэлт гэнэт буурдаг.



Өсөлтийн хурдаар нь:

- Дефляция: $<0\%$

- Мөлхөө: $<3\%$



- Аядуу: $3\% - 10\%$



- Цогмо: $>10\%$



- Гиперинфляци: $>50\%$ (сард!) гэж ангилна.



БОДЛОГЫН ХҮҮ ИНФЛЯЦИД ХЭРХЭН НӨЛӨӨЛДӨГ ВЭ?

Нэг долоо хоногийн хугацаатай Төв банкны үнэт цаас нь банкуудын нөөцийг удирдахад чухал үүрэг гүйцэтгэх бөгөөд Монголбанкны мөнгөний бодлогын үндсэн хэрэгсэл юм.

Энэтөрлийн үнэт цаасны хүү нь Монголбанкны бодлогын хүү болох бөгөөд банк хоорондын зах дээр хөтөч хүүний үүргийг гүйцэтгэдэг.

Төв банкны бодлогын хүү нэмэгдэхийн хэрээр Монголбанкин дахь арилжааны банкуудын харилцах дансанд байршиж буй төгрөгийн нөөц нэмэгддэг.

Ингэснээр гүйлгээнд байгаа бэлэн мөнгөний хэмжээ саарч, барааны үнэ нэмэгдэх дарамт суларч байдаг. Дэлхийн төв банкууд ч мөн адил инфляцитай тэмцэхдээ мөнгөний үнэ цэн буюу бодлогын хүүгээ нэмэгдүүлэн инфляцийг нам тогтвортой түвшинд байлгадаг.

Зарласан огноо	Бодлогын хүү
2015/01/15	13.0
2014/07/31	12.0
2013/06/24	10.5
2013/04/05	11.5
2013/03/13	12.5
2013/01/25	12.5
2012/04/17	13.25
2012/03/19	12.75
2011/10/25	12.25
2011/08/29	11.75
2011/04/28	11.5

Эх сурвалж: Монголбанк

МОНГОЛБАНКНААС ТООЦОН ГАРГАДАГ СУУРЬ ИНФЛЯЦИ ЧУХАМ ЯМАР ҮЗҮҮЛЭЛТ ВЭ?

Хэрэглээний сагсанд зарим бараа үйлчилгээний үнэ улирлын хэлбэлзэл ихтэй байдаг. Гэтэл ийм барааны үнийн хөдөлгөөн нь зарим тохиолдолд эдийн засаг дахь нийт үнийн хөдөлгөөнийг бүдгэрүүлэх, эсвэл бүр төлөөлж чадахгүйд хүрдэг.

Ерөнхий инфляци бол үнийн өөрчлөлтийн хэмжүүр харин суурь инфляци үнийн хандлагын хэмжүүр нь болдог байна. Ийм учраас Төв банкнаас улирлын хэлбэлзэл ихтэй мах, сүү болон хүнсний ногооны дэд бүлгүүдийг ХҮИ-ийн сагснаас хасч инфляцийг дахин тооцож эдийн засаг дахь үнийн ерөнхий түвшин хаашаа хөдөлж байгааг тодорхойлдог билээ. Тус үзүүлэлтийг суурь инфляци гэх бөгөөд суурь инфляци өсөөд эхэлбэл Төв банкнаас түүний эсрэг арга хэмжээ авах магадлал өндөр болдог.



Эх сурвалж: УСХ

ИНФЛЯЦИ ЭДИЙН ЗАСАГТ ЯМАР СӨРӨГ НӨЛӨӨТЭЙ ВЭ?

- | | |
|--|---|
| <ul style="list-style-type: none">Зах зээлийн үр ашиггүй байдлыг нэмэгдүүлж, компаниудын урт хугацааны төлөвлөлт, төсөвт хүндрэл учруулна.Мөнгөний ирээдүйн худалдан авах чадвар тодорхойгүй байх нь хөрөнгө оруулалт, хуримтлал хийх сэдлийг олгохгүй. | <ul style="list-style-type: none">Урт хугацааны ДНБ-д сөргөөр нөлөөлнөОрлогын хуваарьлалтад сөргөөр нөлөөлнө (тогтмол орлоготой иргэд)Төлбөрийн тэнцэлд сөргөөр нөлөөлнөИнфляцийн хүлээлтэд сөргөөр нөлөөлж байдаг |
|--|---|

ДЕФЛЯЦИ ГЭЖ ЮУ ВЭ?

Дефляци нь инфляцийн эсрэг зүйл бөгөөд үнийн ерөнхий түвшин буурах үйл явц юм.

Энэ үзэгдэл нь бараа үйлчилгээг худалдан авах хүмүүсийн эрэлт, хэрэгцээ буурснаар үйлдвэрлэгч компаниудыг өөрсдийн бүтээгдэхүүнийг хямд үнээр борлуулж алдагдал хүлээхэд хүргэдэг үр дагавартай.



ИНФЛЯЦИТАЙ ТЭМЦЭХ АРГА ХЭМЖЭЭ...

1. Мөнгөний бодлого

- Зээлийг хянах
- Шинэ мөнгөн тэмдэгт эргэлтэд оруулах

“Мөнгөний бодлого хэрэгжүүлнэ гэдэг спидометр нь буруу заадаг, тоормоз хэзээ барих нь тодорхойгүй, зам нь арын толинд харагддаг машин жолоодохтой адил”

2. Төсвийн бодлого

- Үр ашиггүй зардлыг бууруулах.
- Татварыг нэмэгдүүлэх.
- Хуримтлалыг нэмэгдүүлэх.
- Төсвийг ашигтай гаргах.
- Улсын өр

3. Бусад арга хэмжээ

- Үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх
- Үр ашигтай цалингийн бодлого
- Үнийн хяналт




ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХҮҮ ӨНДӨР БАЙГАА НЬ ИНФЛЯЦИТАЙ ХОЛБООТОЙ ЮУ?

Жишээ нь: Инфляци жилийн 10 хувь байна гэж бодъё. Та банкинд мөнгөө жилийн 8 хувийн хүүгээр хадгалуулах уу? Хэн ч инфляциас бага түвшинд хадгаламж хийхийг хүсэхгүй. Учир нь инфляцийн түвшин хадгаламжийн хүүнээс өндөр байгаа бөгөөд хадгаламж эзэмшигчид бодит хүүгийн орлого орж ирэхгүй гэсэн үг юм.

Иймдээ ч хадгаламжийн хүү инфляцийн хүүнээс өндөр тогтож байж иргэд банкинд мөнгөө хадгалуулна. Харин хадгаламж эзэмшигчдийн мөнгийг банк зээл болгон гаргахдаа мэдээж үйл ажиллагааны зардлаа нэмэх учраас зээлийн хүү хадгаламжийн хүүнээс өндөр тогтоно.

Инфляци буурснаар хадгаламж, зээлийн хүү буурах боломжтой юм.

Инфляци болон хүү



Фишерийн тэнцэл: $\text{Нэрлэсэн хүү} = \text{Бодит хүү} + \text{Инфляцийн хүлээлт}$

Өндөр инфляци $\rightarrow$ Инфляцийн хүлээлт нэмэгдэнэ $\rightarrow$ Хүү нэмэгдэнэ

ИНФЛЯЦИЙН ӨСӨЛТ ИРГЭДЭД ХЭРХЭН НӨЛӨӨЛДӨГ ВЭ?

Инфляци өндөр байх нь таны орлого, таны мөнгө төдий чинээ үнэгүйдэж байна гэсэн үг. Ингэснээр иргэдийн амьдралын түвшин буурах, хадгаламжийн бодит үнэ цэн буурах, цалин нэмэгдсэн ч жолоодлогогүй инфляцийн улмаас хөдөлмөрлөх сонирхолгүй болох, бүтээмж үйлдвэрлэл буурах, улмаар үйлдвэрлэл буурах, татвар нэмэгдүүлэх хэрэглүүр болдог аюултай.

2005 он



2010 он



2015 он



СЭДЭВ 4:

ЗАСГИЙН
ГАЗРЫН
ҮНЭТ ЦААС

ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ ЦААС ГАРГАХ, АРИЛЖААЛАХ ЖУРАМ

Журмын зорилго:

Засгийн газрын үнэт цаас гаргах, арилжаалах журам нь Засгийн газраас гаргасан үнэт цаасыг анхдагч зах зээлд Монголбанк бусад этгээдэд зуучлан борлуулахад үүсэх харилцааг зохицуулна.

Ач холбогдол:

Засгийн газрын үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа Монголбанкаар дамжин хийгдэх болсноор дараах ач холбогдолтой юм.



Төсвийн бодлогын хувьд:

- Төсвийн богино хугацааны орлого, зарлагын зөрүүг санхүүжүүлэх
- Бүтээн байгуулалтын томоохон төслүүдийг санхүүжүүлэх

Мөнгөний бодлогын хувьд:

- Засгийн газрын үнэт цаасыг мөнгөний бодлогын хэрэгсэл хэлбэрээр ашиглах
- Төсөв, мөнгөний бодлого хоорондын уялдааг сайжруулах

Санхүүгийн зах зээлийн хөгжилд:

- Үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгийн жишиг өгөөжийн муруй бүрэлдэх
- Бусад санхүүгийн хэрэгслүүдийг үнэлэх, зах зээлд нэвтрүүлэх




боломж бүрдэх

Хөрөнгө оруулагчдад:



- Хөрвөх чадвар өндөртэй, эрсдэл багатай хөрөнгө оруулалтын хэрэгсэл
- Засгийн газрын үнэт цаасны хүүгийн орлого татвараас чөлөөлөгдөнө

Засгийн газрын үнэт цаасны арилжааны схем



Тайлбар:

1. Сангийн яам Засгийн газрын үнэт цаасны арилжааны мэдэгдлийг Монголбанкаар дамжуулан зарлах
2. Засгийн газрын үнэт цаас худалдан авах сонирхолтой иргэн, хуулийн этгээд банкаар дамжуулан Монголбанкинд арилжааны санал хүргүүлэх
3. Засгийн газрын үнэт цаасны арилжааны үр дүнг Монголбанк, Сангийн яам мэдээлэх
4. Засгийн газрын үнэт цаасны төлбөрийг шилжүүлэх
5. Үнэт цаасны төлбөр тооцооны төвлөрсөн хадгаламжийн төв Засгийн газрын үнэт цаасны эзэмшигчийн бүртгэлийг хөтлөх

Оролцогч байгууллагууд



САНГИЙН ЯАМ
(ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ)

- ЗГҮЦ-ыг хуваарийн дагуу гаргана



МОНГОЛБАНК
(ЗУУЧЛАН БОРЛУУЛАГЧ)

- ЗГҮЦ-ны дуудлага худалдааг зохион байгуулна



АРИЛЖААНЫ БАНКУУД
(ШУУД ОРОЛЦОГЧ)

- ЗГҮЦ-ны арилжаанд санал ирүүлнэ



- ЗГҮЦ-ны арилжаанд банкаар дамжин оролцоно

ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭД
(ШУУД БУС ОРОЛЦОГЧ)



ҮЦТТХТ
(ҮНЭТ ЦААС БҮРТГЭГЧ)

- Арилжааны мэдээллийг үндэслэн ЗГҮЦ-ны эзэмшигчийн бүртгэлийг хөтөлнө

Засгийн газрын үнэт цаасны төрлүүд

1. Засгийн газрын богино хугацаат үнэт цаас:

Засгийн газрын богино хугацаат үнэт цаас гэж Монгол Улсын Засгийн газраас гаргасан хуанлийн нэг жил ба түүнээс богино хугацаатай өрийн бичгийг хэлнэ. ЗГБХҮЦ–ыг нэрлэсэн үнээр гаргаж, анхдагч зах дээр хямдруулсан үнээр худалдах ба нэрлэсэн үнээр буцаан төлнө.

ЗГБХҮЦ–ыг өгөөжид суурилсан хямдруулсан үнийг дараах томъёогоор бодно:

$$P = \frac{F}{\left[1 + i * \left(\frac{t}{360}\right)\right]}$$

2. Засгийн газрын бонд:

Засгийн газрын бонд гэж Монгол Улсын Засгийн газраас гаргасан хуанлийн нэг жилээс дээш хугацаатай өрийн бичгийг хэлнэ. Засгийн газрын бондыг нэрлэсэн үнээр гаргаж, анхдагч зах дээр арилжаагаар тогтсон үнээр худалдах ба нэрлэсэн үнээр буцаан төлнө. Засгийн газрын бонд нь дуусах хугацаа хүртэл хагас жил тутам төлөгдөх купонтой байна.

Засгийн газрын бондын үнийг дараах томъёогоор бодно:

$$P_{bond} = \sum_{t=1}^m \frac{(P_{par} * i_c / n)}{(1 + YTM/n)^t} + \frac{P_{par}}{(1 + YTM/n)^m}$$

Засгийн газрын үнэт цаасны арилжааны хэлбэр

1. Арилжааны санал:

Өрсөлдөөнт санал: Засгийн газрын үнэт цаасны арилжаанд хүүгээр өрсөлдөх саналыг хэлнэ.

Өрсөлдөөнт бус санал: Ялгавартай үнэтэй арилжааны үед амжилттай биелсэн өрсөлдөөнт саналын жигнэсэн дундаж хүүгээр, нэгдсэн үнэтэй арилжааны үед амжилттай биелсэн саналын өрсөлдөөнт саналын таслагдсан хүүгээр тус тус биелэх саналыг хэлнэ.

2. Арилжааны хэлбэр:

Ялгавартай үнэтэй арилжааны хэлбэр: Шууд оролцогчийн өрсөлдөөнт бус санал нь тухайн арилжааны амжилттай биелсэн өрсөлдөөнт саналын жигнэсэн дундаж хүүгээр, өрсөлдөөнт санал нь тухайн шууд оролцогчийн ирүүлсэн хүүний саналаар биелэх арилжааг хэлнэ.

Нэгдсэн үнэтэй арилжааны хэлбэр: Шууд оролцогчийн өрсөлдөөнт болон өрсөлдөөнт бус санал нь тухайн арилжааны амжилттай биелсэн өрсөлдөөнт саналын таслагдсан хүүгээр биелэх арилжааг хэлнэ.

СЭДЭВ 5:

ИПОТЕКИЙН ЗЭЭЛ
ГЭЖ ЮУ ВЭ?

ИПОТЕК

Ипотекийн зээл гэдэг нь үл хөдлөх хөрөнгөөр баталгаажсан урт хугацаат зээл бөгөөд зээлдэгч нь урьдчилан тодорхойлсон тодорхой хэмжээний төлбөрийг төлөх үүрэг хүлээсэн зээлийг хэлнэ.

Ипотекийн зээл нь зээлдэгч төлбөрийн чадваргүй болсон тохиолдолд барьцааны үл хөдлөх хөрөнгөөр зээлийн төлбөрийг барагдуулах эрхийг зээлдүүлэгчид олгодог.

Ипотекийн зээл болон Моргейжийн зээл нь хоёулаа орон сууцны зээл гэсэн утгатай.



8 ХУВИЙН ХҮҮТЭЙ ОРОН СУУЦНЫ ЗЭЭЛИЙН АЧ ХОЛБОГДОЛ ЮУ ВЭ?

Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бий болгосноор иргэдийн орлого хэрэглээнээс хуримтлал руу шилжинэ.

Иргэдийн хөдөлмөрийн хөлс, үнэлгээ, бүтээмж нэмэгдэж, эдийн засгийн ил тод, тунгалаг байдал бүхэлдээ сайжран, манай улсын Нийгмийн даатгалын сангийн хуримтлал өснө.

Энэ бүхэн нь макро эдийн засгийн тогтвортой байдалд эергээр нөлөөлж, улс орны хэмжээнд хуримтлал нэмэгдэж эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлнэ.



"Н.Бат, эхнэр Б.Цолмонтойгоо нийлээд сард 1 сая төгрөгийн цалин авдаг. Н.Бат, Б.Цолмон хоёр өөрийн гэсэн байргүй аав, ээжийнхээ хажуу өрөөнд амьдардаг бөгөөд цалингийнхаа дийлэнх хувийг хоол, хувцас, найзуудтайгаа уулзах зэрэгт зарцуулдаг. Хуримтлал хийдэггүй.

Тэд орон сууцны зээлд хамрагдсанаар сар бүр цалингийнхаа тодорхой хувийг зээлдээ өгч үлдсэн мөнгөөр амьжиргаагаа залгуулах шаардлага үүссэнээр санхүүгийн хувьд сахилга баттай зарцуулалт хийх болов. Тэдэнд бүрэн зуун хувь төлбөрийг нь төлөөд орон сууцанд орох боломж байгаагүй учраас зээлд хамрагдсан бөгөөд энэхүү орон сууц нь тэдний хуримтлал буюу ирээдүйн баялаг болж байна."

ОРОН СУУЦНЫ ЗЭЭЛИЙН УРЬДЧИЛГАА ЯМАР АЧ ХОЛБОГДОЛТОЙ ВЭ?

Урьдчилгаа төлбөр нь зээлдэгчийн зээлийн эргэн төлөлтөд дарамт учруулахгүй байх, банкны салбарыг эрсдэлээс хамгаалах, санхүүгийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн маш чухал зохицуулалт юм.



БАНКУУДЫН ИРГЭДЭД ОЛГОСОН ОРОН СУУЦНЫ ЗЭЭЛИЙН ХЭМЖЭЭ ХЭД ХҮРСЭН БЭ?

2015 оны 10 дугаар сард банкуудын ипотекийн зээлийн үлдэгдэл 3370.5 тэрбум төгрөг, нийт зээлдэгчдийн тоо 75877–д хүрчээ.

Тайлант сарын эцэст ипотекийн зээлийн үлдэгдлийн 75.2 хувь буюу 2534.5 тэрбум төгрөгийг “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр”-ийн зээл (жилийн 8 хувийн хүүтэй зээл болон 8 хувийн хүүтэй зээлд шилжүүлсэн зээл), 22.9 хувь буюу 770.3 тэрбум төгрөгийг банкуудын өөрийн эх үүсвэрээр олгосон зээл, 1.9 хувь буюу 65.7 тэрбум төгрөгийг бусад эх үүсвэрээр олгосон зээл бүрдүүлж байна.

2015 оны 10 дугаар сарын байдлаар ипотекийн зээлийн үлдэгдлийн 98.4 хувь нь төгрөгийн зээл, 1.6 хувь нь гадаад валютын зээл байна.



Эх сурвалж: Монголбанк

ИПОТЕКИЙН ЗЭЭЛДЭГЧДИЙН ТОО ХЭДЭД ХҮРЭЭД БАЙНА?

2008 онд 16522 хүн орон сууцны зээл авсан бол 2012 онд 26869, 2014 онд 66334, 2015 оны 7 дугаар сарын байдлаар энэ үзүүлэлт 73208 болж өсчээ.



Эх сурвалж: Монголбанк

НИЙТ ЗЭЭЛИЙН ХЭДЭН ХУВЬ НЬ ХӨДӨӨ ОРОН НУТАГТ ОЛГОГДСОН БЭ?

2015 оны 9 дүгээр сарын байдлаар банкуудын ипотекийн зээлийн үлдэгдлийн 76.9 хувийг Улаанбаатар хотод, 23.1 хувийг хөдөө орон нутагт олгосон ипотекийн зээл

бүрдүүлжээ. Хөдөө орон нутаг дахь ипотекийн зээлийн үлдэгдлийн 15.0 хувь буюу 114.8 тэрбум төгрөг Дархан-Уул аймагт, 14.1 хувь буюу 107.9 тэрбум төгрөг Орхон аймагт, 8.9 хувь буюу 68.4 тэрбум төгрөг Дорноговь аймагт ногдож байна.

Аймгууд	Ипотекийн зээлийн		Үүнээс ОСИСТБХ-ийн зээл		Тухайн сард олгосон ипотекийн зээлийн ЖДХугацаа (сар)	Тухайн сард олгосон ипотекийн зээлийн ЖДХүү (жилээр)	Нийт зээлдэгчдийн тоо	Үүнээс: ОСИСТБ хөтөлбөрийн зээлтэй
	Үлдэгдэл (сая төг.)	Эзлэх хувь	Үлдэгдэл (сая төг.)	Эзлэх хувь				
1 Улаанбаатар	2,553,262.8	76.9%	1,872,813.6	75.5%	197.2	9.5	50762	49,508
2 Дархан-Уул	114,828.9	3.5%	100,518.9	4.1%	200.1	9.5	3370	451
3 Орхон	107,859.6	3.2%	93,822.4	3.8%	190.7	8.6	2862	417
4 Дорноговь	68,379.3	2.1%	55,744.6	2.2%	186.9	9.5	1997	444
5 Дорнод	47,399.8	1.4%	42,212.2	1.7%	190.8	7.8	1511	387
6 Сэлэнгэ	45,539.0	1.4%	35,958.1	1.4%	185.2	8.8	1561	166
7 Өвөрхангай	42,542.2	1.3%	29,965.4	1.2%	165.0	10.5	1493	241
8 Увс	41,426.0	1.2%	29,828.7	1.2%	173.3	12.0	1395	183
9 Өмнөговь	40,720.2	1.2%	30,747.5	1.2%	178.4	8.6	1134	239
10 Баянхонгор	33,456.5	1.0%	30,050.0	1.2%	187.1	11.4	871	255
11 Ховд	31,068.7	0.9%	25,697.5	1.0%	159.3	10.9	1062	248
12 Сүхбаатар	25,856.8	0.8%	17,477.5	0.7%	202.0	11.3	880	165
13 Архангай	22,628.1	0.7%	17,653.9	0.7%	210.0	8.1	665	115
14 Баян-Өлгий	21,760.7	0.7%	11,060.9	0.4%	101.9	14.9	1068	126
15 Говь-Алтай	18,596.6	0.6%	15,050.4	0.6%	228.6	8.0	606	82
16 Хөвсгөл	17,587.8	0.5%	9,336.2	0.4%	171.0	13.0	714	79
17 Завхан	17,296.3	0.5%	10,548.8	0.4%	154.3	12.5	669	70
18 Хэнтий	15,809.7	0.5%	13,464.5	0.5%	211.6	8.9	475	137
19 Төв	14,782.8	0.4%	10,906.7	0.4%	180.6	9.2	464	93
20 Дундговь	14,326.4	0.4%	11,028.8	0.4%	206.4	11.8	450	87
21 Говьсүмбэр	12,470.5	0.4%	11,137.5	0.4%	201.5	8.0	402	98
22 Булган	12,113.1	0.4%	6,532.9	0.3%	215.8	9.9	437	52
Нийт	3,319,711.8	100%	2,481,556.8	100%	194.8	9.6	74848	53643

Эх сурвалж: Монголбанк


“ОРОН СУУЦНЫ САНХҮҮЖИЛТИЙН УРТ ХУГАЦААНЫ ТОГТВОРТОЙ ТОГТОЛЦООГ БИЙ БОЛГОХ” ХӨТӨЛБӨР

Монголбанк болон Монгол Улсын Засгийн газар хамтран орон сууцны ипотекийн 8 хувийн зээлийн хөтөлбөрийг 2013 оны 06 дугаар сараас хэрэгжүүлж эхэлсэн.

ХӨТӨЛБӨРИЙН АЧ ХОЛБОГДОЛ

- Зах зээлийн зарчимд суурилсан төрийн зохистой оролцоог бий болгох;
- Орон сууцны санхүүжилтийн тогтвортой, урт хугацааны тогтолцоог бэхжүүлэх;
- Ипотекийн хоёрдогч зах зээлийг хөгжүүлэх;
- Орон сууцны хүртээмжийг нэмэгдүүлэх;
- Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх;
- Институциональ хөрөнгө оруулагчийг бий болгосноор үнэт цаасны захын хөгжлийг дэмжих;
- Агаарын бохирдлыг бууруулах, хүний хөгжлийн үндэс суурь болсон хүн амын эрүүл мэндийг хамгаалах, хүн амын амьдрах орчин, чанарыг сайжруулах.

“Орон сууцны санхүүжилтийн урт хугацааны тогтвортой тогтолцоог бий болгох”
хөтөлбөр



СЭДЭВ 6:


ЭДИЙН ЗАСГИЙН МӨЧЛӨГ

ЭДИЙН ЗАСГИЙН МӨЧЛӨГ ГЭЖ ЮУ ВЭ?

Эдийн засгийн үйл ажиллагаа нь цаг хугацаанд нэг идэвхжиж, нэг буурч байдаг бөгөөд үүнийг эдийн засгийн мөчлөг буюу хэлбэлзэл гэнэ.

Макро эдийн засгийн үзүүлэлтүүдийн динамикийг харвал тэдгээр нь богино хугацаанд ихээхэн хэлбэлзэлтэй байдаг.

Энэ нь эдийн засгийн үйл ажиллагаа цаг хугацаанд нэг идэвхжиж, нэг буурч байдагтай холбоотой.



ЭДИЙН ЗАСГИЙН МӨЧЛӨГИЙН ҮЕ ШАТУУД

Эдийн засгийн үйл ажиллагаа идэвхижиж байвал өрнөлт, буурч байвал уналт гэж нэрлэнэ. Эдийн засгийн үйл ажиллагаа нь үйлдвэрлэлтэй нэгэн зэрэг өөрчлөгддөг тул түүнийг үйлдвэрлэлээр хэмжинэ. Үнэндээ үйлдвэрлэлийг дотоодын нийт бүтээгдэхүүнээр хэмждэг тул эдийн засгийн үйл ажиллагаа бодит ДНБ-ээр хэмжигддэг.

Мөчлөг нь өрнөлт, уналтаас бүрдэнэ. Уналтын доод цэгээс оргил хүртэл эдийн засгийн өрнөлт үргэлжлэх ба оргилоос доод цэг хүртэл уналт үргэлжилнэ.

Мөчлөгийн оргилоос (доод цэгээс) урт хугацааны хандлага хүртэлх зайг мөчлөгийн далайц гэж нэрлэнэ.

ЭДИЙН ЗАСГИЙН МӨЧЛӨГИЙН ҮЕД МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН ТӨЛӨВ

Эдийн засгийн үйл ажиллагаа нь цаг хугацаанд нэг идэвхижиж, нэг буурч байдаг бөгөөд үүнийг эдийн засгийн мөчлөг буюу хэлбэлзэл гэнэ.

Макро эдийн засгийн үзүүлэлтүүдийн динамикийг харвал тэдгээр нь богино хугацаанд ихээхэн хэлбэлзэлтэй байдаг.

Энэ нь эдийн засгийн үйл ажиллагаа цаг хугацаанд нэг идэвхижиж, нэг буурч байдагтай холбоотой.

СЭДЭВ 7:

ХАНШИЙН БОДЛОГЫН АСУУДЛУУД

ВАЛЮТЫН ХАНШ ГЭЖ ЮУ ВЭ?

Валютын ханш гэдэг нь тухайн улсын мөнгөн тэмдэгтийг өөр улсын мөнгөн тэмдэгтээр худалдах, худалдан авах “үнэ” юм.

Валютын ханш нь тухайн валютын эрэлт, нийлүүлэлтээр тодорхойлогдох ба дэлхийн



бусад улс оронтой хийх бүх төрлийн эдийн засгийн харилцаанд ашиглагдаж, дотоодын эдийн засагт нөлөө үзүүлдэг макро түвшний үзүүлэлт тул нээлттэй эдийн засгийн хувьд чухал үнэ юм.

Валютын ханшийг ерөнхийд нь нэрлэсэн ба бодит гэж ангилна.

БОДИТ ХАНШ НЭРЛЭСЭН ХАНШААС ЯМАР ЯЛГААТАЙ ГЭЖ?

Нэрлэсэн ханш гэж гадаад орны мөнгөн тэмдэгттэй харьцах үндэсний мөнгөн тэмдэгтийн шууд ханшийг, харин бодит ханш гэж нэрлэсэн ханшаас үнийн нөлөөг хасч тооцсон ханшийг хэлнэ.

Нэрлэсэн үйлчилж буй ханш (Nominal effective exchange rate) гэж гадаад худалдааны түнш орнуудын валюттай харьцах төгрөгийн нэрлэсэн ханшийн индексүүдийн жигнэсэн дундаж буюу дан ганц ам.доллар, евро гэлтгүй гадаад худалдааны түнш бүх орны үндэсний мөнгөн тэмдэгттэй харьцах төгрөгийн нэрлэсэн дундаж ханшийг хэлнэ. Нэрлэсэн үйлчилж буй ханшийг NEER гэж тэмдэглэнэ.

Бодит үйлчилж буй ханш (Real effective exchange rate) гэж гадаад худалдааны түнш орнуудын валюттай харьцах төгрөгийн бодит ханшийн индексүүдийн жигнэсэн дундаж буюу гадаад худалдааны түнш бүх орнуудын үндэсний мөнгөн тэмдэгттэй харьцах төгрөгийн бодит дундаж ханшийг хэлнэ. Бодит үйлчилж буй ханшийг REER гэж тэмдэглэнэ.

$$\Delta REER = \Delta NEER + \text{Инфляци}$$



ХАНШИЙН ДЭГЛЭМ

Ханшийн үндсэн гурван дэглэм байдаг.

- Тогтмол ханшийн дэглэм (Бүгд Найрамдах Куб Улс, Непал, Арабын Нэгдсэн Эмират Улс...)
- Чөлөөтэй хөвөгч ханшийн дэглэм (Австрали, АНУ, ИБУИНВУ, Япон...)
- Удирдлагатай хөвөгч ханшийн дэглэм (Монгол Улс, Турк, Солонгос...)



ТОГТМОЛ ХАНШИЙН ДЭГЛЭМ

Валютын тогтмол ханшийн дэглэмийн үед тухайн улсын Төв банк үндэсний валютын бусад улсын валюттай харьцах ханшийг тогтмол түвшинд барих бөгөөд үүний тулд Төв банк нь гадаад валютын хангалттай нөөцтэй байх шаардлагатай.

Давуу тал:

- Валютын ханшийн тодорхой байдал
- Инфляцийн дарамт бага

Сул тал:

- Мөнгөний бодлогын бие даасан байдал алдагддаг.
- Төлбөрийн тэнцэл зах зээлийн зарчмын дагуу тэнцвэрждэггүй.
- Валют арилжааны дамын наймааг өдөөдөг.



ЧӨЛӨӨТЭЙ ХӨВӨГЧ ХАНШИЙН ДЭГЛЭМ

Чөлөөтэй хөвөгч ханшийн дэглэмийн үед Төв банк үндэсний валютын ханшийг зах зээлд чөлөөтэй хэлбэлзэж байхыг хүлээн зөвшөөрдөг бөгөөд аливаа нэг зохицуулах, хөндлөнгөөс оролцох бодлого авч хэрэгжүүлэхгүй.

Давуу тал:

- Мөнгөний бодлогын бие даасан байдал
- Төлбөрийн тэнцэл зах зээлийн зарчмын дагуу тэнцвэржих

Сөрөг тал:

- Эдийн засагт огцом хэлбэлзэл бий болох эрсдэлтэй.
- Инфляцын дарамтыг нэмэгдүүлдэг.

Уг дэглэм нь том зах зээлтэй хөгжингүй орнуудад илүү үр дүнтэй байдаг.



УДИРДЛАГАТАЙ ХӨВӨГЧ ХАНШИЙН ДЭГЛЭМ


Удирдлагатай хөвөгч ханшийн дэглэмийн үед валютын ханш валютын эрэлт, нийлүүлэлт буюу валютын урсгалаар тодорхойлогдох боловч валютын захад ханшийн огцом хэлбэлзэл бий болсон үед Төв банк нь хэлбэлзлийг зөөлрүүлэх зорилгоор интервенц хийдэг.

Давуу тал:

- Зах зээлийн ханшийн өөрчлөлтөд дасан зохицох, хүлээлтээ удирдах боломжийг олгосноор ААН-үүд үйл ажиллагаагаа тогтвортой удирдан явуулах нөхцөлийг бүрдүүлэх
- Эдийн засаг, санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах

Сөрөг тал:

- Гадаад валютын нөөц хуримтлагдах нөхцөлийг бүрдүүлдэггүй.



БОЛОМЖГҮЙН ГУРВАЛЖИН?

Нобелийн шагналт эдийн засагч Р.Манделл, ОУВС-ын судалгааны захирал Ж.Флемин нар 1960-аад онд тус тусдаа валютын ханшийн тогтвортой байдал, мөнгөний бие даасан бодлого, хөрөнгийн чөлөөт урсгал гэсэн гурван зорилт нэгэн зэрэг биелэх боломжгүй, эдгээрээс зөвхөн хоёр нь л нэгэн зэрэг биелэх боломжтой гэдэг дүгнэлтийг хийсэн байдаг. Улмаар үүнийг БОЛОМЖГҮЙН ГУРВАЛЖИН гэж нэрлэх болсон.

Тогтмол валютын ханш, хөрөнгийн чөлөөтэй урсгал, бие даасан мөнгөний бодлогыг нэг дор хэрэгжүүлбэл санхүүгийн хямралд хүргэдэг гэж үздэг. Тухайлбал:

- Мексикийн Песо хямрал (1994–95)
- 1997 оны Азийн санхүүгийн хямрал (1997–98)
- Аргентины санхүүгийн хямрал (2001–02)

Монгол Улсын хувьд хөрөнгийн чөлөөтэй урсгалтай буюу гаднаас орж гарах валютад ямар нэгэн хязгаарлалт тавьдаггүй, Төв банк нь инфляцийг зорилт болгосон байдаг тул валютын ханшийг тогтмол барих боломжгүй юм.



МОНГОЛ УЛС УЯН ХАТАН ХАНШИЙН ДЭГЛЭМИЙГ МӨРДДӨГ

Монгол Улс нь 1993 онд уян хатан ханшийн дэглэмд шилжсэн бөгөөд үүнд дараах хүчин зүйлс нөлөөлсөн:

- Уул уурхайн салбараас хамаарал өндөртэй тул дэлхийн зах зээл дэх түүхий эдийн үнийн хэлбэлзлээс мэдрэмтгий (ДНБ, төсвийн орлого, экспорт) буюу хэлбэлзэл өндөртэй. Тиймээс ханшийн хэлбэлзэл өндөртэй.
- Хувийн хэвшилд валютын ханш, зах зээлийн өөрчлөлтөд дасан зохицох, эрсдэлээ удирдах боломжийг олгох зорилгоор Монголбанк нь ханшийн хэт хэлбэлзэл, валютын хомсдол үүссэн үед валютын захад оролцож эдийн засаг, санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах нь зүйтэй гэж үзсэн.

ВАЛЮТЫН ЗАХАД ХЭРХЭН ОРОЛЦДОГ ВЭ?

Монголбанк нь валютын дотоодын захад гадаад валютын дуудлага худалдаа буюу интервенцийн аргаар оролцдог.

Интервенц нь валютын дотоодын захын үйл ажиллагааг ил тод, нээлттэй явуулах, үр ашгийг нэмэгдүүлэх, валютын ханшийн тогтвортой байдлыг хангах, зах зээлийн зарчмаар тодорхойлох Төв банкны валютын захад оролцох нэг арга хэрэгсэл юм.

Өөрөөр хэлбэл, шаардлагатай тохиолдолд Төв банкнаас валютын захад валют

худалдах, худалдан авах үйл ажиллагаа явуулдаг.

Монголбанк нь гадаад валютын дуудлага худалдааг долоо хоног бүрийн Мягмар, Пүрэв гарагт тогтмол зохион байгуулдаг ба дуудлага худалдаанд зөвхөн банкны үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй, Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй банкууд оролцдог. Дуудлага худалдааны мэдээлэл Монголбанкны цахим хуудсанд тухай бүр тавигддаг.



САНХҮҮГИЙН ҮҮСМЭЛ ХЭРЭГСЛҮҮД

Валютын захад оролцогчдыг ханшийн эрсдэлээс хамгаалахын тулд санхүүгийн үүсмэл хэрэгслүүдийг ашигладаг.

Түгээмэл ашиглагддаг хэрэгслүүд:

- Своп хэлцэл – тухайн өдрийн ханшаар валют худалдан авч (худалдаж) ирээдүйн тохиролцсон ханшаар эргүүлэн худалдах (худалдан авах) хэлцлийг хэлнэ.
- Форвард хэлцэл – талуудын хэлцлийн дагуу валютыг тохирсон үнээр тодорхой хугацааны дараа худалдах, худалдан авах үйл ажиллагааг хэлнэ.

2010 онд Монголбанкнаас своп, форвард хэлцлийг нэвтрүүлсэн...

Своп хэлцэл

"Төгрөгийн своп хэлцэл" гэж хэлцэл хийгдэх үед Монголбанк төгрөг татаж, ам.доллар нийлүүлж хугацааны эцэст Монголбанк ам.доллар татаж, төгрөг нийлүүлэх хэлцлийг

"Ам.долларын своп хэлцэл" гэж хэлцэл хийгдэх үед Монголбанк ам.доллар татаж, төгрөг нийлүүлж хугацааны эцэст Монголбанк төгрөг татаж, ам.доллар нийлүүлэх хэлцлийг

"Юаний своп хэлцэл" гэж тодорхой хугацааны эцэст Монголбанк бэлэн бус төгрөгийн зээлийн дүнг, хүүгийн хамт банкинд эргүүлэн төлөх, банк бэлэн бус юаний зээлийн дүнг хүүгийн хамт эргүүлэн төлөх нөхцөлтэй олгосон хэлцлийг ойлгоно.

Форвард хэлцэл

"Төгрөгийн форвард хэлцэл"
Хугацааны эцэст Монголбанк төгрөг худалдан авч, ам.доллар худалдах хэлцлийг.

"Ам.долларын форвард хэлцэл"
Хугацааны эцэст Монголбанк ам.доллар худалдан авч, төгрөг худалдах хэлцлийг ойлгоно.

ХАНШИЙГ ХЭН ТОГТООДОГ ВЭ?

Арилжааны банк, ББСБ нь өөрсдийн ханшийг тогтооно.

Харин Монголбанк нь банкуудын жигнэсэн дундаж ханшийг тооцож, Монголбанкны албан ханшийг зарладаг.

Монголбанкны албан ханшийг зөвхөн албан хэрэгцээнд буюу гааль, шүүх, нягтлан бодох, татвар зэрэгт ашиглана.



 CANADA	CAD	0.9512	0.8883
 CHINA	CNY	7.3169	6.0910
 EURO	EUR	0.6644	0.6100
 JAPAN	JPY	109.00	102.00
 SINGAPORE	SGD	1.3712	1.2630
 HONG KONG	HKD	7.0043	6.4072
 NEW ZEALAND	NZD	1.1646	1.0675
 MALAYSIA	MYR	3.2536	2.7818

МОНГОЛ УЛСЫН ГАДААД ВАЛЮТЫН АЛБАН НӨӨЦ

Улсын гадаад валютын албан нөөц нь төрийн эрх бүхий байгууллага болон арилжааны банкны эзэмшилд байгаа гадаадын банк, санхүүгийн байгууллагад хадгалж байгаа мөнгөжсөн алт, чөлөөтэй хөрвөдөг гадаад валют, гадаадын үнэт цаасны зах дээр чөлөөтэй борлогдох үнэт цаас болон бусад олон улсын хэмжээнд валютын нөөцөд тооцогдох үнэт зүйлээс бүрдэнэ.

Монголбанк Монгол Улсын валютын гадаад нөөцийг удирдаж, нэмэгдүүлэх арга хэмжээ авах үүрэгтэй.

ГВАН = Монголбанкны эзэмшилд байгаа, захиран зарцуулахад бэлэн, чөлөөтэй хөрвөдөг гадаад валют.

ГВАН = Улсын үндэсний мөнгөн тэмдэгтэд итгэх итгэл, гадаад өр төлбөрийг барагдуулах, төлбөрийн тэнцлийн алдагдлыг санхүүжүүлэх баталгаа, гадаад секторын тогтворгүй байдлыг даван туулах хэрэгсэл.



СЭДЭВ 8:

ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ

ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ ГЭЖ ЮУ ВЭ?

Төлбөрийн тэнцэл бол тухайн улсын эдийн засгийн гадаад бодлогын (Англи) нэрийн хуудас гэж эдийн засагчид үздэг.

Төлбөрийн тэнцэл нь өнгөц харахад “статистик” гэсэн утгаар техникийн шинжтэй асуудал гэж ойлгогдож магадгүй ч, энэ нь аливаа эдийн засгийн гадаад тэнцлийг илэрхийлэгч, макро эдийн засгийн хамгийн чухал үндсэн үзүүлэлтийн нэг юм.

Олон улсын нийтлэг аргачлалын дагуу “төлбөрийн тэнцэл” гэж аливаа улсын эдийн засгийн харьяатын гадаад эдийн засагтай буюу эдийн засгийн харьяат бустай тодорхой



хугацаанд хийсэн худалдаа, үйлчилгээ, хөрөнгө, санхүүгийн болон бусад урсгалын орлого, зарлагын гүйлгээг системчлэн нэгтгэсэн статистикийн тайланг хэлдэг.

Энэхүү статистик нэгтгэл нь аливаа улсын гадаад ертөнцтэй харилцах эдийн засгийн харилцааг харуулахаас гадна, тус улсын эдийн засгийн ерөнхий төлөв байдал, хандлагын талаарх мэдээллийг харуулж байдаг.

ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ ГЭЖ ЮУ ВЭ?

Төлбөрийн тэнцэлийг үндсэн гурван бүлгийн дансаар боловсруулна. Үүнд:

1. Урсгал данс

- Бараа
- Үйлчилгээ
- Цэвэр орлого
- Цэвэр шилжүүлэг

2. Хөрөнгө ба санхүүгийн данс

2.1. Хөрөнгийн данс

2.2. Санхүүгийн данс

- Гадаадын шууд хөрөнгө оруулалт
- Багцын хөрөнгө оруулалт
- Бусад хөрөнгө оруулалт

ТӨЛБӨРИЙН ТЭНЦЛИЙН АЛДАГДАЛ

Төлбөрийн тэнцэл алдагдалтай байна гэдэг нь экспорт нь импортынхоо төлбөрийг хийж чадахгүй байна гэсэн үг юм.

Урсгал тэнцлийн алдагдал гэдэг нь энгийн үгээр монголчуудын гадаадад гаргаж худалдаалдаг бараа, үйлчилгээ, шилжүүлгийн орлогоос гаднаас авдаг бараа, үйлчилгээ, шилжүүлгийн төлбөрийг хассан цэвэр дүн буюу монголчууд юуг бүтээж, валютын ямар орлого олов? Юуг гаднаас авч, ямар хэмжээний валютын төлбөр гадагш нь төлөв гэдгийг харуулдаг эдийн засгийн суурь үзүүлэлт юм. Энэ үзүүлэлт (-) утгатай байна гэдэг нь бидний олж байгаа валютын орлого нь бидний гадагш нь төлдөг валютын хаана ч хүрдэггүй гэсэн үг.




СЭДЭВ 9:

МОНГОЛБАНКНЫ
СТАТИСТИКИЙГ
ХЭРХЭН АШИГЛАХ ВЭ?

СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ

Монголбанк нь мөнгө, санхүүгийн өргөн хүрээтэй статистикийг боловсруулж нэгтгэн нийтэлдэг.

Статистик цэсний байрлал



Монголбанкны www.mongolbank.mn цахим хуудасны Статистик дэд цэснээс дараах үндсэн тайлан, статистик үзүүлэлтийг харах боломжтой:

- Валютын ханш
- Ипотекийн зээлийн тайлан
- Төлбөрийн тэнцлийн статистик
- Гадаад хөрөнгө оруулалтын позицын тайлан
- Гадаад өрийн статистик
- Гадаад худалдааны тойм
- Гадаад секторын тойм
- Мөнгөний тойм
- Банкуудын нэгдсэн тайлан тэнцэл
- Статистик бюллетень
- Төв банкны үнэт цаасны хүү
- Алтны үнэ
- Инфляци
- Бусад

ВАЛЮТЫН ХАНШ

Статистик → Ханшийн статистик

Цахим хуудасны дээр дурдсан хэсгээс Монголбанкнаас зарлаж байгаа ханшийн статистикийг дараах төрлөөр харах боломжтой:

- Төв банкны тухайн өдрийн албан ханш
- Ханшийн хөдөлгөөн
- Ханшийн сарын дундаж хөдөлгөөн
- Нэрлэсэн болон бодит үйлчилж буй ханшийн индекс
- Валютын дуудлага худалдааны зарласан хаалтын ханш

Анхаарах!

Монголбанк нь 2010 оны 12 дугаар сарын 07–ны өдрөөс эхлэн “ТУХАЙН ӨДРИЙН ХААЛТЫН ХАНШ”-ийг зарлаж байгаа бөгөөд энэ ханшийг Монголбанкнаас зарласан дараа өдрийн ханш гэж тооцно.

Дурдаж буй ханшийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь заалтад заасан Монголбанкнаас зарласан ханш гэж ойлговол зохино.

Нэрлэсэн үйлчилж буй ханшийн индекс нь энгийнээр төгрөгийн бусад худалдааны түнш орнуудын валютын эсрэг үнийн хөдөлгөөнийг илэрхийлнэ. Тус индексийн утга өсвөл төгрөгийн ханш чангарч байна гэж ойлгоно.

Бодит үйлчилж буй ханш нь худалдааны түнш орнууд ба Монгол Улсын инфляциар засварласан төгрөгийн ханшийг илэрхийлнэ. Нэрлэсэн үйлчилж буй ханшаас инфляцийн нөлөөг хасч тооцвол төгрөгийн ханш ямар байгааг эндээс харж болно.

Валютын зарласан ханш



Эх сурвалж: Монголбанк

ИПОТЕКИЙН ЗЭЭЛИЙН ТАЙЛАН

Монголбанк нь сар бүрийн 20–24–нд арилжааны банкуудын ипотекийн зээлийн тайланг бэлтгэн цахим хуудаснаа байршуулдаг.

Уг тайлангаас ипотекийн зээлд хамрагдсан нийт зээлдэгчдийн тоо, зээлийн хүү, өмнөх оны мөн үе болон өмнөх сартай харьцуулсан үзүүлэлт зэрэг холбогдох тоог харах боломжтой.

НҮҮР ХОУДАС \ СТАТИСТИК \ **БАНКУУДЫН ИПОТЕКИЙН ЗЭЭЛИЙН ТАЙЛАН**

Банкуудын ипотекийн зээлийн тайлан

• 2015

- 10-р сар
- 09-р сар
- 08-р сар
- 07-р сар
- 06-р сар
- 05-р сар
- 04-р сар
- 03-р сар
- 02-р сар
- 01-р сар

• 2014

- 12-р сар
- 11-р сар
- 10-р сар
- 09-р сар
- 08-р сар
- 07-р сар

Буцах

Нэмэлт мэдээ, материал

Мөнгөний статистик нэгдэлд оруулсан өөрчлөлтүүд

Мөнгөний статистик үзүүлэлтүүдийг тооцох арга, нэгдэллийн эх үүсвэр

Санхүүгийн хэрэгслүүд болон хуримтлуулж тооцсон хүчний авлага, өглөгт секторын ангилал хийх заавар

Банк хоорондын төгрөгийн зах

Төгрөгийн нэрлэсэн ба бодит үйлчилж буй ханш тооцох аргачлал

IFS Supplement on Monetary and Financial Statistics

Статистик нэгдэллийг тархах хуваарь

ТӨЛБӨРИЙН ТЭНЦЛИЙН СТАТИСТИК

Статистик → Гадаад секторын статистик → Төлбөрийн тэнцэл

Төлбөрийн тэнцэл, гадаад хөрөнгө оруулалтын позицын статистикийн асуудал нь өнгөц харахад “статистик” гэсэн утгаар техникийн шинжтэй асуудал гэж ойлгогдож магадгүй ч, энэ нь аливаа эдийн засгийн гадаад тэнцлийг илэрхийлэгч, макро эдийн засгийн хамгийн чухал үндсэн үзүүлэлтийн нэг юм.

Төлбөрийн тэнцлийн статистикийг Монголбанк нь сар бүрийн 27–31–нд цахим хуудаснаа байршуулдаг.

Энэ нь Монгол Улсын эдийн засгийн харьяат ба харьяат бусын хооронд хийгдэж буй бүх төрлийн ажил, гүйлгээг тусгадаг. Төлбөрийн тэнцэл нь тухайн тайлант үеийн ажил, гүйлгээгээр тайлагнагддаг бол гадаад хөрөнгө оруулалтын позицын тайлан нь өссөн дүнгээр тайлагнагддаг.

Төлбөрийн тэнцэл, агуулга



ГАДААД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ПОЗИЦЫН ТАЙЛАН

Статистик → Гадаад секторын статистик → Гадаад хөрөнгө оруулалтын позиц

Гадаад хөрөнгө оруулалтын позицын тайланг Монголбанк улирал бүрийн дараагийн 2 дахь сарын 25-ны өдрийн дотор цахим хуудаснаа байршуулдаг.

Энэ нь төлбөрийн тэнцлийн тайлангийн санхүүгийн дансны үлдэгдлийг харуулдаг тайлан юм. Тодруулбал, тайлант үеийн гадаад хөрөнгө оруулалтын позицын өөрчлөлт нь мөн үеийн төлбөрийн тэнцлийн тайлангийн харгалзах дансны дүнтэй тэнцүү байна.



ГАДААД ӨРИЙН СТАТИСТИК

Статистик → Гадаад секторын статистик → Гадаад өр

Гадаад өрийн статистикийг Монголбанк нь улирал бүрийн дараагийн 2 дахь сарын 25-ны өдрийн дотор цахим хуудаснаа байршуулдаг. (Жишээлбэл 3-р улирлын мэдээлэл 11 сарын 25-ны дотор гарна.)

Энэ нь Монгол Улсын хувийн болон улсын нийт гадаад өрийн хэмжээг илэрхийлдэг бөгөөд өссөн дүнгээр тайлагнагддаг.

Гадаад өр/ДНБ




Эх сурвалж: mecometer.com

МӨНГӨНИЙ ТОЙМ

Мөнгөний тоймд үнэ, мөнгө, зээл, мөнгөний зах болон валютын ханшийн статистиكت гарсан өөрчлөлт, хандлагыг тайлбарлан танилцуулдаг.

Монголбанк нь сар бүрийн 22-24-нд “Мөнгөний тойм”-ыг цахим хуудаснаа байршуулдаг.



Эх сурвалж: Монголбанк

БАНКУУДЫН НЭГДСЭН ТАЙЛАН ТЭНЦЭЛ

Банкуудын нэгдсэн тайлан тэнцэл гэдэг нь Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй бүх арилжааны банкны хөрөнгө, өр төлбөр болон өмчийн мэдээллийг тухайн өдрөөр нэгтгэн харуулсан санхүүгийн байдлын илэрхийлэл юм. Нэгдсэн тайлан тэнцлийн актив талд хөрөнгө, харин пассив талд өр төлбөр болон өөрийн хөрөнгийг бүртгэдэг:

Актив = Пассив + Өөрийн хөрөнгө

Тухайн банк нь санхүүгийн тайлангаа улирал бүр өдөр тутмын сонин хэвлэлээр дамжуулж иргэд, олон нийтэд мэдээлж байхаар Банкны тухай хуульд заасан байдаг.

Банкуудын нэгдсэн тайлан тэнцлийг Монголбанк нь бүрэн 16–17–нд цахим хуудаснаа байршуулдаг.

АРИЛЖААНЫ БАНКУУДЫН НЭГДСЭН ТАЙЛАНГИЙГ ХӨҮҮЛЭХЭЛТҮҮД

(хүн тэрэгнээр)

Арилжааны банк/урилгуур	10/31/2014	12/31/2014	1/31/2015	2/28/2015	3/31/2015	4/30/2015	5/31/2015	6/30/2015	7/31/2015	8/31/2015	9/30/2015	10/31/2015
Батмөнч банк	2,250,921.4	1,012,085.1	2,477,190.8	2,383,492.4	2,166,627.6	1,961,156.0	1,977,990.3	2,009,193.0	2,612,697.8	2,465,127.7	2,096,368.9	1,763,749.4
ТБЦҮТ	654,262.8	852,983.3	362,304.0	429,574.9	384,618.6	314,511.6	1,009,805.0	1,150,480.3	479,441.2	310,483.9	625,661.1	855,433.5
Галдан арил	931,126.2	675,479.7	852,210.3	860,351.4	678,991.1	807,647.8	834,536.1	913,997.8	1,045,996.1	1,206,115.9	1,034,485.9	879,776.6
ЗҮЦҮ	2,062,678.6	2,088,072.2	2,095,960.7	2,151,081.5	2,129,362.7	2,115,626.7	2,197,673.0	2,291,040.0	2,553,350.8	2,152,744.4	2,141,525.6	2,292,502.4
Улаан шаш	256,219.7	241,364.6	333,519.5	888,378.8	433,901.1	477,888.3	498,498.2	391,068.6	499,751.8	770,072.4	612,820.0	633,139.3
Эвнэ	12,773,887.9	12,440,925.9	12,607,220.7	12,117,433.0	12,211,911.3	12,273,222.5	12,110,369.2	11,881,967.3	11,627,123.6	11,775,664.9	11,877,167.6	11,847,871.5
Төрийн банк	9,695,095.9	9,564,409.0	9,133,124.0	9,199,251.3	9,135,301.6	9,342,932.6	9,292,091.7	9,009,262.3	8,991,512.3	8,833,652.0	9,012,278.4	9,020,920.0
Батмөнч банк	3,676,762.0	2,876,516.9	2,886,068.7	2,919,191.7	2,996,009.7	2,894,268.9	2,818,360.1	2,872,349.9	2,953,610.3	2,941,622.5	2,868,807.2	2,826,593.7
Батмөнч банк/урилгуур	694,519.5	621,817.9	653,632.4	665,454.5	701,393.4	745,479.4	737,082.4	771,939.9	822,664.7	803,232.3	814,587.0	831,211.3
Нийт арилжааны	20,976,826.1	22,582,376.8	20,623,008.9	20,748,751.8	20,778,313.4	20,498,826.8	21,462,990.8	21,861,611.6	21,459,322.4	21,597,312.2	21,346,329.2	20,766,621.5

Пассив/урилгуур	10/31/2014	12/31/2014	1/31/2015	2/28/2015	3/31/2015	4/30/2015	5/31/2015	6/30/2015	7/31/2015	8/31/2015	9/30/2015	10/31/2015
Харилцаа	2,780,799.3	2,756,315.1	2,235,537.2	2,264,276.2	2,142,904.5	2,199,281.4	2,205,790.6	2,298,855.5	2,211,557.2	2,297,917.9	2,248,819.0	2,155,244.8
Төрийн банк	2,268,586.3	1,317,400.1	1,119,291.2	1,118,361.7	1,055,354.8	1,088,734.9	1,171,249.7	1,231,252.2	1,231,627.9	1,231,427.7	1,268,297.8	1,162,591.0
Батмөнч банк	1,467,178.8	1,439,053.1	1,172,974.1	1,128,394.5	1,087,120.5	1,028,549.3	1,014,541.4	1,065,115.2	1,011,020.3	1,064,732.1	1,062,321.2	992,635.7
Харилцаа	6,709,422.7	7,335,168.3	7,515,405.5	7,472,210.3	7,327,177.8	7,146,322.7	7,262,804.0	7,346,990.2	7,160,998.2	7,230,590.0	7,233,505.7	7,233,505.7
Төрийн банк	3,652,629.3	3,771,881.9	3,394,129.6	3,316,339.9	3,144,588.2	3,057,025.0	3,154,252.5	3,244,143.0	3,103,427.0	3,027,071.6	3,113,098.1	3,171,272.2
Батмөнч банк	1,657,391.4	1,961,194.4	2,165,140.9	2,155,891.4	2,182,599.1	2,086,261.7	2,198,272.1	2,610,722.4	2,941,461.2	2,142,026.6	2,995,419.9	2,862,340.6
Галдан арил	2,213,682.4	2,491,107.7	2,488,373.9	2,595,552.9	2,543,800.2	2,471,017.8	3,342,482.2	3,526,325.8	3,763,774.8	3,759,361.2	3,138,422.2	3,176,308.7
Батмөнч банк	1,777,243.4	1,864,591.7	1,435,935.5	1,452,148.8	1,413,350.0	1,348,956.1	1,371,122.5	1,357,006.4	1,299,291.4	1,265,111.9	1,466,673.9	1,434,126.6
Нийт арилжааны	19,060,425.0	20,440,108.6	18,471,164.8	18,547,419.4	18,561,397.4	18,828,779.9	19,125,922.6	19,535,163.6	19,411,496.5	19,527,487.4	18,957,145.8	18,327,319.2

Өөрийн хөрөнгө	1,915,296.1	2,134,288.2	2,151,839.0	2,193,311.4	2,216,805.9	2,268,055.8	2,337,686.2	2,325,081.6	2,247,535.9	2,284,444.7	2,409,185.3	2,419,317.3
Төрийн банк/урилгуур	213,685.6	325,982.1	276,662.4	461,213.3	715,671.0	103,229.2	183,847.4	179,685.6	143,909.9	266,019.7	266,019.7	220,421.2

ТАГАН БУУДСАН БАНКУУДЫН ХАССАГААР

(хүн тэрэгнээр)

Арилжааны банк/урилгуур	10/31/2014	12/31/2014	1/31/2015	2/28/2015	3/31/2015	4/30/2015	5/31/2015	6/30/2015	7/31/2015	8/31/2015	9/30/2015	10/31/2015
-------------------------	------------	------------	-----------	-----------	-----------	-----------	-----------	-----------	-----------	-----------	-----------	------------

Эх сурвалж: Монголбанк

Монголбанкны статистикийг хэрхэн ашиглах вэ?

СТАТИСТИК БЮЛЛЕТЕНЬ

Бюллетеньд Төв банк болон арилжааны банкуудын нэгдсэн тайлан тэнцэл, мөнгөний тойм, зээлийн өрийн үлдэгдэл, ХҮИ, хадгаламж, зээлийн хүү, худалдааны тэнцэл, төсвийн гүйцэтгэл, үнэт цаасны зах зээлийн мэдээ зэрэг статистик агуулагддаг.

Сар бүрийн 16–18–нд Монголбанк нь Статистик бюллетенийг цахим хуудаснаа байршуулдаг.

МОНГОЛБАНК
СТАТИСТИКИЙН САРЫН БЮЛЛЕТЕНЬ



BANK OF MONGOLIA
Monthly Statistical Bulletin
2015-10

ГАДААД ХУДАЛДААНЫ ТОЙМ

Статистик → Гадаад секторын статистик → Гадаад худалдааны тойм

Монголбанк нь энэхүү тоймыг Гаалийн Ерөнхий газрын “Гадаад худалдааны барааны статистик мэдээлэл”-д үндэслэн, дэлхийн улс орнуудын Төв банкны практикт нийцүүлж, судалгаа шинжилгээний ажлын хэрэгцээнд зориулан боловсруулдаг.

Сар бүрийн 20-нд Монголбанк нь Гадаад худалдааны тоймыг цахим хуудаснаа байршуулдаг.



ГАДААД ХУДАЛДААНЫ САРЫН ТОЙМ

2015 оны 11 дүгээр сар

Гадаад худалдааны эргэлт: \$7,737.5 сая

Мөнгөн дүр тайлент хувиарын эхэт 1,737.5 сая ам.долларт тус тус өсөж 20.8-аар буруу 2,280.0 сая ам.доллараар буурсан. Үүнээс импорт 947.5 сая ам.доллараар, экспорт 1,337.5 сая ам.доллараар тус тус буурсан нь нөлөөрсөн.

Хэри-орнуудтай хийсэн худалдааг он үзэлт, нийт бараа эргэлтийн 62.4% буюу 4,811.9 сая ам.долларын худалдааг БНМАУ устгал, 13.0% буюу 1,002.5 сая ам.долларын худалдааг ОХУ-тай тус тус хийсэн байна. БНМАУ-тай хийсэн худалдаа өнгөрсөн онд мөн үеэс 21.5%-иар, ОХУ-тай хийсэн худалдаа 32.3%-аар тус тус буурсаар.

Гадаад худалдааны нийт тэнцэл: \$748.2 сая

Мөнгөн дүр 2015 оны зөвхөн 11 сарын байдлаар гадаад худалдааны тэнцлийн ашиг өнгөрсөн онд мөн үеэс 390.0 сая ам.доллараар өсөжсөөрөө 748.2 сая ам.долларын ашигтай гарлаа. Энэ нь импорт 19.3%-аар буурсан ч импорт түүрхс өндөр дүнгээр буюу 21.7%-аар буурсантай холбоотой байна.

Экспорт, импортын жилийн өсөлтийн эерүүг 3 сарын туслам дүнгээр (тооцог өөрчлөх) аж үзэс сүүлийн жилүүдэд байнгын бүртгэлтэй байсан боловч 2014 оны зансас экспорт өсөлт өсөжсөн, импортын өсөлт буурсан тул жилийн өсөлтийн эерүү өсөжсөн. Хэри 2015 он гарвар зохион байгуулсан импортын мөнгө тэсрүүлж, барааны эргэлтийн өсөлт буруу байна.

Валютын төлбөртэй худалдааны тэнцэл: \$1041.2

Валютын төлбөр тооцог нь гүйцэтгэлт худалдааны тэнцэл нь төлбөрийн хамттай харцаа зансас нөлөөлсөн суурь үзүүлэлт юм. Сүүлийн 2 жилийн хугацаанд тогтмол алдагдалтай байсан валютын төлбөртэй худалдааны тэнцэл 2015 оны сүүлийн жилдээ зансас тогтмол ашигтай гар байлаа. 2015 оны зөвхөн 11 сарын гүйцэтгэлтэр 1,041.2 сая ам.долларын ашигтай буюу өнгөрсөн онд мөн үеэс 398.7 сая ам.доллараар сайжирсан үзүүлэлт байлаа. Үүнээс валютын төлбөртэй импорт 30.6%-аар буурсан нь нөлөөлсөн.

Гадаад худалдааны нөхцөл: 1,254 (үржүүлсэн тооцоо)

2015 оны 11 дүгээр сарын байдлаар гадаад худалдааны нөхцөлийн индекс өсөж онд мөн үеэс 21.3%-аар, өмнөх сарын 10.9%-аар буруу 1,254-а хүрчээ.


Гадаад худалдааны нөхцөл өмнөх үеэр-хөгжсөөд импортын үнийн индекс өсөж онд мөн үеэс хэрхүүлжээ 12.5%-аар, экспортын үнийн индекс 10.4%-аар буурсан нь голлон нөлөөлсөн байна. Экспортын үнийн бүртгэлтэй зохион байгуул, төлбөрийн худал, түүний нефтийн хийн худал улс бусад нь голлон нөлөөлсөн бол импортын үнийн бүртгэлтэй нефтийн бүтээгдэхүүнийг үлс бусад нь голлон нөлөөлсөн байна.

Эхнэр мөнгө 100 ам.долларын-баруун статистикын мэдээлэл-д үндэслэн, дэлхийн улс орнуудын Төв Банкны үзүүлэлт өөрчлөх, сүүлийн санхүүжилт мөнгө хэрхүүлж өөрчлөх боломжтой.


Тайлбар: 1. Гадаад худалдааны гүйцэтгэлт хая ам.доллар

Төрөл	Дөхөв 11 сар			Өөрчлөлт		
	2015	2014	2013	2015/2014	2015/2013	
Эргэлт	7 737.5	10 622.8	9 718.4	(2 284.3)	(22.4%)	30.1%
Экспорт	4 263.9	5 150.4	3 882.2	(947.5)	(-9.4%)	15.4%
Импорт	2 494.0	4 552.2	5 836.2	(1 058.2)	(-18.1%)	10.9%
Тэнцэл	748.2	390.2	1 004.1	390.0	38.9%	410.0%


Тайлбар: 2. Экспорт, импортын валютын хэрэгсэл 3 сарын туслам дүнгээр



Тайлбар: 3. Валютын төлбөртэй худалдаа



Тайлбар: 4. Хэрхүүлсэн-нөхцөлийн индексийн өөрчлөлт 3 сарын туслам дүнгээр



Эх сурвалж: Монголбанк

ГАДААД СЕКТОРЫН ТОЙМ

Статистик → Гадаад секторын статистик → Гадаад секторын тойм

Гадаад секторын тойм нь төлбөрийн тэнцэл, гадаад хөрөнгө оруулалтын позиц, гадаад өрийн улирлын эцсийн гүйцэтгэл гарсны дараа Монголбанкнаас зарлаж буй гадаад секторын статистикуудыг тоймлон, тус секторын тойм мэдээ, голлох өөрчлөлт зэргийг товч байдлаар олон нийтэд хүргэхэд чиглэсэн тайлан юм.

Улирал бүрийн дараагийн хоёр дахь сарын сүүлийн өдрөөс өмнө Монголбанк нь Гадаад секторын тоймыг цахим хуудаснаа байршуулдаг.



СЭДЭВ 10:

ОРЧИН ҮЕИЙН
БАНКНЫ ЭХЛЭЛ

ОРЧИН ҮЕИЙН БАНКНЫ ЭХЛЭЛ

Банк нь хүн төрөлхтний нийгмийн хөгжлийн явцад бий болсон томоохон ололтын нэг юм. Хүй нэгдлийн нийгэм задарч мөнгө хүүлэх, капитал үүсэх үед банкны үйл ажиллагааны анхны үр хөврөл бий болсон байна.

Эзэндээ тодорхой хэмжээний хүүгийн орлого авч ирдэг, мөнгөн капиталын гүйлгээ өргөжиж, зохион байгуулалтад орох болсон нь банкны үйл ажиллагааны эхлэл болжээ. Банкны зарим үйл ажиллагааг гүйцэтгэх тусгай байгууллага ч бий болсон байна.

Судлаачид банк гэдэг нь “Banko” орчуулбал “Вандан” гэсэн утгатай Итали гаралтай үг гэж үздэг. Түүхийн ном хэвлэлд тэмдэглэснээс үзэхэд, эртний Вавилон, Грек, Египет, Римд XIV–XV зууны үед банкны үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд анх гарч ирж комиссын гүйлгээнээс эхлээд зээл олгох хүртэл ажил эрхэлж эхэлсэн байна.

Манай эриний өмнөх 8 дугаар зууны Вавилоны банк мөнгөн хадгаламж авч, зээл олгохын зэрэгцээ “гуду” гэдэг нэртэй цаасан мөнгө гүйлгээнд гаргаж байжээ. Мөн эртний Вавилонд мөнгө хүүлэх, арилжих явдал их дэлгэрсэн байв. Иймээс засгийн зүгээс иргэдийн хоорондын зээлийн харилцааг зохицуулах, мөнгө хүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах оролдлого хийж байсан.

Грект банкны үйл ажиллагааг сүсэгтнүүд гүйцэтгэж байв. Худалдаа, наймааны үйл ажиллагаа ихээхэн өргөжих болсон нь банкны гүйлгээ хөгжихөд түлхэц болжээ. Зээлийн хэрэгцээ их гарах болсон нь мөнгө зээлдүүлэх банкны гүйлгээ хөгжих эхлэл болсон байна.

Бага хэмжээний зээлийн гүйлгээ гол төлөв гар дамжиж, зарим үед жижиг лангуу (трапеца), тусгай байранд төвлөрөн хийгдэж байв. Гар үйлдвэр эрхлэгчид лангууныхаа

ард суугаад худалдаа наймаа хийж, мөнгө солих, зээлдүүлэх ажил эрхэлж байсан бөгөөд үүнээс Грекийн “трапеза” буюу “лангууны ард суугаа хүн” гэсэн утгатай үг гаралтай ажээ. Харин томоохон хэмжээний зээл олгох, мөнгө солилцох гүйлгээ Грект сүм хийдэд хийгдэж байжээ. Ер нь сүм хийд нь банкны гүйлгээ хийдэг болон мөнгөө хадгалдаг гол газар буюу нэг ёсны банкны үүргийг гүйцэтгэдэг байв.

Эртний Грекийн 30 гаруй хотод трапезийн буюу лангуугаар мөнгө солих гүйлгээ хийдэг байсан. Сүм хийдэд ард түмэн итгэдэг байсан тул тэнд байрлаж байгаа мөнгөний лангуу, конторт мөнгөө хадгалуулах, худалдах, худалдан авах, солилцох гүйлгээ хийхэд хамгийн тохиромжтой газрын нэг байв.

Манай эриний өмнөх 3 дугаар зууны үед грекүүд зоосон мөнгө цутгаж гүйлгээний хэрэгсэл болгон ашигласан бөгөөд энэ нь арилжаа наймааны ажилд том өөрчлөлт гаргасан байна. Сүүлдээ сүм хийдийн мөнгөний гүйлгээ өргөжиж, тэндээс зээл олгох, улсын болон худалдаачдын мөнгө, эд хөрөнгийг хадгалах, зоосон мөнгийг солилцох, гүйлгээг зуучлах, мөнгөний гүйлгээний данс, бүртгэл хөтлөх болж, түүний үйл ажиллагаа нь банкны ажлын хэв шинжид ихээхэн ойртсон байна.



Улс хоорондын худалдаа хөгжихийн хэрээр зоосон мөнгөний гүйлгээ өсч, тэдгээрийг худалддаг, худалдан авдаг тусгай конторууд ажиллах болсон байна. Энэ нь орчин үеийн банкны эхлэл байжээ. Ялангуяа дундад зууны үед Италид ийм конторууд их дэлгэрч, тэдгээрийг Италиар “banko” гэж нэрлэж байжээ. Үүнээс үзэхэд “банк” гэдэг үг нь Итали

үгнээс гаралтай байж болох юм.

Гэхдээ банк гэдэг үгний гарал үүслийн талаар хоёр таамаглал байдгийн эхнийх нь дээр дурдсан Итали үг болох “banco” буюу мөнгөний контор, мөнгөний авдар гэсэн утгатай. Харин хоёр дахь таамаглал нь мөнгөний арилжаа хийдэг хүмүүсийн байрладаг “контор” буюулангуу гэдэг үгтэй холбоотой ажээ.

XII–XIII зууны үед Италийн Генуя, Рим, Флоренц, Милан зэрэг хотуудад арилжаа наймаа бусдаас илүү хөгжиж, мөнгө хүүлэх үйл ажиллагаа их дэлгэрсэнтэй уялдаж, мөнгө хүүлэгчид нөхөрлөл байгуулж, мөнгө зээлдүүлэх, хадгаламж авах болжээ.

Орчин үеийн банкны хэв шинжийг агуулсан банк 1407 онд Италийн Генуя хотод “Ариун Георгия” нэртэйгээр анх байгуулагдсан байна.

Энэ банк нь хадгаламжийн хоршоо, нөхөрлөлүүдийн хэлбэрээр улсын оролцоотойгоор байгуулагдсан. Энэ үеэс Италид барьцаалж зээл олгодог ломбардууд үүсчээ. Мөн 1587 онд Венецид улсын буюу жиробанк болох “Banco di Rielto” байгуулагдаж, хожим нь түүнээс салбарлан хадгаламжийн банк, кассууд, орон сууцны банк зэрэг жиробанкууд байгуулагдсан байна. 1893 онд Италийн үндэсний банк байгуулагдаж, 1923 оноос эмиссийн онц эрхтэй болж, Төв банкны үүрэг гүйцэтгэх болжээ.

XVI–XVII зуунд Нидерланд, Германд банкны үйл ажиллагаа явуулж байсан банкны контор, мөнгөний болон зээлийн хоршоо зэрэг нь банкууд болж гарч ирсэн байна. Германы банкны



хөгжлийн түүх мөн л бусад орныхтой адил байсан бөгөөд 1648 онд “Гемайн-Кредит” нэртэй анхны банк байгуулагдаж байсан бол 1870 он гэхэд 30 гаруй банк үйл ажиллагаа явуулж байжээ. Харин 1875 оноос эмиссийн гүйлгээ алхам алхмаар улсын хяналтад орох болжээ. XX зууны эхэн үе гэхэд банкны тоо 400 гарч, Рейхсбанкны (Бундесбанк буюу Төв банкиг өмнө нь ингэж нэрлэж байжээ) үүрэг ихээхэн нэмэгдсэн байна. 1934 онд зээлийн системийн тухай хууль, 1939 онд Рейхсбанкны тухай хууль тус тус гарч орчин үеийн банкны эрх зүйн үндэс бүрдэж эхэлсэн байна.

Англи Улсад 1664 онд “Английн банк” нэртэй анхны банк байгуулагдсан байна. Английн Төв банкиг анх 1200 гаруй хувь нийлүүлэгчдийн хөрөнгөөр байгуулсан бөгөөд алт, мөнгө худалдах, худалдан авах, вексель гаргах, зээл олгох зэрэг үйл ажиллагаа эрхэлж байв. 1972 оноос Төв банк эмиссийн онц эрхтэй болж, орчин үеийн Төв банкны хэв шинж рүү шилжих эхлэл нь тавигдсан байна.



1979 онд Банкны тухай хууль гарах хүртэл банкны талаар тодорхойлолт өгөх горимын эрхийн дүрэм байсангүй. Асуудлын гол нь горимын эрх нь энэ асуудлаас тойрч гарсан тул Парламентын хуулинд банкны үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байгаа нөхөрлөл, хоршооллын байгууллага, компани гэж банкиг тодорхойлсон.

Америкт XVIII зууны дунд үеэс банкны үйл ажиллагаа эрхлэх явдал бие даасан зохион байгуулалтад орсон байна. 1781 онд Филадельфид “Хойд Америкийн банк”

нэртэй анхны банк байгуулагдсан бөгөөд 1800 онд 29, 1820 он гэхэд 300 гаруй банк ажиллах болж тэдгээр нь эдийн засгийн чухал дэд бүтэц болсон байна. 1863 – 1864 онд Америкт Үндэсний валютын тухай болон Арилжааны банкны тухай хуулиуд гарч, банкны систем ажиллах эрх зүйн үндсийг бүрдүүлсэн байна.

Орос Улсад XVII зууны дунд үе хүртэл бие даасан банкны байгууллага байсангүй. Харин 1729–1733 онд банкны үйл ажиллагаа эрхлэх мөнгөний контор нэртэй байгууллага бий болж, алт мөнгийг барьцаалан богино хугацаатай зээл олгох болжээ. Хожим нь 1754 онд хатан хаан Елизавете Петровнагийн захирамжаар Москва, Санкт–Петербург хотод контор бүхий Улсын банкиг хөрөнгөтэй хүмүүст зориулан байгуулж, тэр нь 1785 он хүртэл ажиллажээ.

Оросын банкны хөгжлийн түүхэнд болсон томоохон үйл явдал нь одоогийн Төв банкны үндэс болох Улсын банк 1860 онд байгуулагдсан явдал юм. Харин 1991 оноос Банкны тухай шинэ хуулиар арилжааны банкууд бие даасан эрхтэй болсны гадна хувийн болон хамтын өмчинд суурилсан банкууд байгуулагдах болов.

Монгол туургатан эрт дээр үеэс металл болон цаасан мөнгө гарган гүйлгээнд хэрэглэж байсан түүхтэй. Мөнх хааны үед буюу 1253 онд цаасан мөнгөн дэвсгэрт гаргаж, мөнгөний хэрэг эрхлэх газар байгуулан ажиллуулж байжээ. Хубилай хаан Хархорумд 1260 онд мөнгө тушаах банк байгуулж, 1282 оноос “Олон замд тэгшитгэх банк” нэртэй банкны салбаруудыг байгуулан ажиллуулж байсан ажээ.

Харин Манж, Хятадын дарлалын үед энэ түүхэн уламжлал тасарч Монголын зах зээл дээр Хятад, Оросын зэрэг валютууд өргөн хэрэглэгдэж байсны дээр 19 дүгээр зууны сүүлээр Нийслэл хүрээ, Улиастай зэрэг газар Хятад, Оросын зарим банкны салбар ажиллаж байжээ. Харин 1921 оны ардын хувьсгалын дараа Монгол Улсад үндэсний банк, зээлийн систем хөгжих боломж бүрдсэн байна.

СЭДЭВ 11:

САНХҮҮГИЙН
ТОГТВОРТОЙ БАЙДАЛ БА
МАКРО ЗОХИСТОЙ
БОДЛОГО

САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

Санхүүгийн тогтвортой байдал гэдэг нь үнэ тогтоох, нөөц хуваарилах, санхүүгийн эрсдэлийг удирдах зэрэг эдийн засгийн тогтолцоонууд нь эдийн засгийн өсөлт, хөгжлийг дэмжихэд чиглэгдсэн байхаас гадна зах зээлийн гэнэтийн таагүй нөлөөлөл, хямралын үед мөн адил ажиллах чадвартай байхыг хэлэх бөгөөд ерөнхийдөө тухайн улсын санхүүгийн системийн найдвартай байдлыг санхүүгийн тогтвортой байдал гэнэ.

Санхүүгийн тогтвортой байдлыг тухайн улсын эдийн засгийг бүх талаас нь цогц байдлаар авч үзэн шинжилж, хэрэв эдийн засагт тогтвортой бус нөхцөл байдал үүсвэл хэрхэх вэ гэдгийг авч үзсэний үндсэн дээр тодорхойлох боломжтой бөгөөд ингэхдээ тухайн санхүүгийн системийн төлбөрийн чадвар буюу эдийн засгийн нөөц бололцоо, үр ашиг, түүний хуваарилалт, эрсдэлийн удирдлага, эдийн засаг дахь гэнэтийн таагүй



гадаад нөлөөлөл болон хямралын үед тухайн санхүүгийн системийн ажиллах чадвар зэргийг чухалчлан авч үздэг юм.

Иймээс үр ашигтай, тогтвортой санхүүгийн систем нь бодит үйлдвэрлэлийн өсөлт болон эдийн засгийн нөөцийн үр дүнтэй хуваарилалтыг дэмжиж, санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагааг үнэн зөв, ил тод болгон, хуримтлал, хөрөнгө оруулалт бий болгох замаар баялагийг бүтээх, хөгжлийг бий болгох, бизнес эрхлэгчид үйл ажиллагаагаа тогтвортой явуулах нөхцөлийг бүрдүүлэх, мөнгө, санхүүгийн захын зээлийн тогтвортой байдлыг хангах зэрэгт чиглэгдсэн байдаг бөгөөд мөн урьдчилан тооцоолоогүй санхүү, эдийн засгийн хямрал болон тогтвортой бус байдал үүсэхэд энэхүү таагүй нөхцөл байдлыг сарниулж, эдийн засаг дахь сөрөг нөлөөллийг даван туулах чадвартай байдаг.

ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Банкны системийн найдвартай тасралтгүй ажиллагааг хангахын тулд Монголбанкнаас банкуудад зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг мөрдүүлж хяналт тавьдаг. Санхүүгийн системийн болзошгүй эрсдэлээс сэргийлэхийн тулд тухайн нөхцөлд нийцсэн мөчлөг сөрсөн макро эдийн засгийн цогц бодлого явуулах нь илүү үр дүнтэй юм. Банкуудын зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд, төсвийн болон мөнгөний бодлогын арга хэрэгслүүдийг мөчлөг сөрсөн байдлаар ашиглах нь мөчлөгийн далайцыг багасгах, уналтын үеийг хамгийн бага хохиролтойгоор даван туулахад тусалдаг.

№	Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд
1	"Банкны өөрийн хөрөнгийн хүрэлцээ" => 12% "Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын зохистой харьцаа" => 9%
2	Зээлийн төвлөрлийн эрсдэлийн үзүүлэлтүүд: А. Нэг зээлдэгч, түүнд холбогдох этгээдэд олгосон зээлийн нийт өөрийн хөрөнгөнд эзлэх хувь <= 20% Б. Хувь нийлүүлэгч, банкны ажилтан, тэдгээрт холбогдох этгээдэд олгосон зээл: – Нийлбэр нь өөрийн хөрөнгөд эзлэх хувь <= 20% – Нэг этгээдийн хувьд өөрийн хөрөнгөд эзлэх хувь <= 5%
3	Үндсэн хөрөнгийн харьцаа <= 8%
4	Гадаад валютын актив, пассивын зохистой харьцаа: Нэгж валютын хувьд <+/- 15% Нийт валютын хувьд <+/- 40%
5	Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой хэмжээ >= 25%

№	Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд
1	"Банкны өөрийн хөрөнгийн хүрэлцээ" => 12% "Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын зохистой харьцаа" => 9%

2	Зээлийн төвлөрлийн эрсдэлийн үзүүлэлтүүд:
	А. Нэг зээлдэгч, түүнд холбогдох этгээдэд олгосон зээлийн нийт өөрийн хөрөнгөнд эзлэх хувь $\leq 20\%$
	Б. Хувь нийлүүлэгч, банкны ажилтан, тэдгээрт холбогдох этгээдэд олгосон зээл:
	– Нийлбэр нь өөрийн хөрөнгөд эзлэх хувь $\leq 20\%$ – Нэг этгээдийн хувьд өөрийн хөрөнгөд эзлэх хувь $\leq 5\%$
3	Үндсэн хөрөнгийн харьцаа $\leq 8\%$
4	Гадаад валютын актив, пассивын зохистой харьцаа:
	Нэгж валютын хувьд $\leq \pm 15\%$
	Нийт валютын хувьд $\leq \pm 40\%$
5	Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой хэмжээ $\geq 25\%$

* – Сүүлийн 6 сарын туршид банкны системийн нийт активын 5 хувиас дээш хувийг бүрдүүлж байгаа банкуудад Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар нэмэлт өөрийн хөрөнгийн хэмжээг тогтооно.

МАКРО ЗОХИСТОЙ БОДЛОГО

Урт хугацаанд тогтвортой, хүртээмжтэй эдийн засгийн өсөлтийн чухал суурь нөхцөл нь макро эдийн засгийн тогтвортой байдал юм. Макро эдийн засгийн тогтвортой байдал гэдэгт эдийн засгийн дотоод тэнцвэр буюу бүрэн ажил эрхлэлттэй үеийн үнийн тогтвортой байдал, гадаад тэнцвэр буюу төлбөрийн урсгал тэнцлийн урт хугацааны тогтвортой байдал гэсэн хоёр үндсэн нөхцөл зэрэг хангагдах төлөвийг түгээмэл авч үздэг. Дэлхий



нийтийг хамарсан санхүү, эдийн засгийн хямралаас өмнөх хугацаанд уламжлалт мөнгөний бодлого нь өөрийн зорилтдоо хүрч, өсөлтийг дэмжихийн сацуу үнийн тогтвортой байдлыг бий болгож байсан ч бодлогын хүрээнд орхигдсон зүйл нь санхүүгийн тогтвортой байдлыг хангах явдал байв. Тухайлбал,

макро эдийн засгийн тогтвортой байдал удаан үргэлжилсэн нь санхүүгийн зах зээлд оролцогчдын хувьд системийн эрсдэлийг дутуу үнэлэх, илүү эрсдэлд дуртай болох хандлагыг бий болгосон бөгөөд санхүүгийн салбар дахь хангалтгүй хяналт, шалгалт, зохицуулалт, мэдээллийн хүртээмжгүй байдал зэрэг нь түүнийг улам бүр өдөөсөн байдаг. Ийнхүү макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангахын зэрэгцээ санхүүгийн тогтвортой байдлыг хангах, түүнд чиглэсэн бодлого хэрэгжүүлэх нь чухал болохыг давтамж болон хохирлын хэмжээ нь нэмэгдсээр буй санхүүгийн хямралууд сануулсаар буй юм.

Санхүүгийн тогтвортой байдал гэдэгт санхүүгийн систем нь төлбөр тооцоо, санхүүгийн хөрөнгийг бий болгож, түүнийг оновчтой хөрөнгө оруулалтад үр ашигтайгаар хуваарилах, эрсдэлийг тараан байршуулах зэрэг үндсэн үүргээ ямар нэг нийгмийн томоохон зардал, сааталгүйгээр хэвийн гүйцэтгэж чадаж байх явдлыг ойлгодог. Санхүүгийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн салбарыг гүнзгийрүүлэхэд тавигдах гол суурь нөхцөл нь санхүүгийн зуучлал үргэлж зохистой хэм хэмжээнд явагдаж байх юм. Ялангуяа, макро эдийн засгийн нөхцөл таатай, хөрөнгийн орох урсгал давамгайлсан, банкны системийн хөрвөх чадвар өндөр үед банкны зээлийн бодлого зохистой байгаа эсэхэд илүү анхаарал хандуулах шаардлагатай. Учир нь гол төлөв энэ үед санхүүгийн тогтворгүй, тэнцвэргүй байдал, зах зээлийн гажуудал, хямралын эрсдэл хуримтлагддаг. Энэ нь өнгөрсөн хямралын тохиолдлуудад нийтлэг ажиглагдсан зүй тогтол юм.

Санхүүгийн тогтвортой байдлыг хангах гэдэгт хямрал болон санхүүгийн

тогтвортой байдлыг урьдчилан таах, дохиолох гэхээс илүү санхүүгийн системийн үйл ажиллагаа эрүүл, зохистой хэм хэмжээнд явагдаж буй эсэхэд чиглэсэн байнгын хяналт, шалгалт, тогтворжуулалтын болон системийн эрсдэлийг бууруулах идэвхтэй бодлогыг тохиромжтой институцийн хүрээнд бусад бодлогын хэрэгслүүдтэй харилцан уялдаатайгаар хэрэгжүүлэхийг ойлгох хэрэгтэй юм.

Хэдийгээр санхүүгийн тогтвортой байдлыг хангах нь, аль институцийн бодлогын зорилт байх нь тухайн улс орны уламжлалт институцийн загвар, хууль, эрх зүйн орчин зэргээс хамаарах боловч санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилтыг хэрэгжүүлэх институцийн загвар төв банкиндаа суурилсан байх нь оновчтой болохыг судлаачид зөвлөж байна. Энэ тохиолдолд санхүүгийн тогтвортой байдлын зорилтыг мөнгөний бодлогын зорилттой хэрхэн уялдуулах нь гол асуудал юм.

Макро эдийн засгийн онолд Нобелийн шагналт эдийн засагч Тинбергений нэрээр нэрлэгдсэн зарчим байдаг. Уг зарчим ёсоор, тодорхой тооны бодлогын зорилтод хүрэхийн тулд бодлогын шийдвэр гаргагчид дор хаяж түүнтэй тэнцүү тооны бодлогын хэрэгсэл ашиглах хэрэгтэй байдаг. Өөрөөр хэлбэл, хоёр өөр бодлогын зорилтод нэг бодлогын хэрэгслээр хүрэх боломжгүй гэсэн үг юм. Тухайлбал, хөрөнгийн урсгалд хяналт зохицуулалт хийх нэмэлт бодлогын хэрэгсэл ашиглахгүйгээр дан ганц уламжлалт мөнгөний бодлогын хэрэгсэл болох хүүгийн бодлого ашиглан үнэ болон ханшийн тогтвортой байдлыг нэгэн зэрэг хангах боломжгүй гэж үздэг нь үүний нэг тод жишээ юм. Үүнийг бид боломжгүйн гурвалжин (impossible trinity) гэж нэрлэдэг. Уг зарчим ёсоор, Төв банк үнийн тогтвортой байдлын үндсэн зорилттой зэрэгцэн санхүүгийн тогтвортой байдлыг хангах бодлогын зорилттой бол заавал нэмэлт бодлогын хэрэгсэл буюу макро зохистой бодлогын хэрэгслийг ашиглах шаардлага урган гардаг. Дан ганц хүүг өсгөх замаар санхүүгийн тогтвортой байдлыг хангах гэж оролдох нь маш их зардалтай байдаг. Түүний оронд, тохирсон, тодорхой эрсдэл үүсч буй салбарт чиглэсэн макро

зохистой бодлогын арга хэрэгсэл ашиглах нь үр ашигтай байна. Хэдийгээр тусдаа өөр, өөр бодлогын хэрэгсэл ашиглагдаж байгаа мэт боловч үнийн тогтвортой байдал болон санхүүгийн тогтвортой байдал нь харилцан уялдаа, хамаарал бүхий зорилтууд учир (нэгнийгээ орлох ёсгүй) бодлого нь хоорондоо нийцтэй, нэгдмэл цогц байх ёстой байдаг. Тухайлбал, инфляци буурах хүлээлттэй үед мөнгөний бодлого хүүг бууруулах шийдвэр гаргах бөгөөд бага хүүгийн орчин нь санхүүгийн салбарын эрсдэлийг өсгөх хүчин зүйл болж болно. Энэ мэт бодлогын сонголтоос үүдэн мөнгөний бодлого нь санхүүгийн бодлоготой нийцтэй байх шаардлага бий болдог.

Дэлхий улс орнуудын Төв банкуудад албан болон албан бус хэлбэрээр хамгийн өргөнөөр ашиглагдаж ирсэн мөнгөний бодлогын загвар нь инфляцийг онилох мөнгөний бодлого юм. Анх 1989 онд Шинэ Зеланд улс Төв банкныхаа хуулинд түүний үүргийн зөвхөн үнийн тогтвортой байдлыг хангах гэсэн утгаар тусгаснаар инфляцийг онилох мөнгөний бодлого нь хатуу (strict) хэлбэрээрээ практикт ашиглагдаж эхэлсэн гэж үздэг. Цаашлаад мөнгөний бодлого нь дан ганц үнийн тогтвортой байдлаас гадна эдийн засгийн өсөлтөд давхар анхаарлаа хандуулах болсноор уян хатан инфляцийг онилох бодлого болон хувьсаж ирсэн байдаг. Өөрөөр хэлбэл, бүрэн ажил эрхлэлттэй үеийн инфляцийн нам, тогтвортой түвшинд хүрэх нь бодлогын зорилттой болсон бөгөөд эдийн засгийн өсөлт, үнийн тогтвортой байдал хоёрын оновчтой балансыг олох нь уян хатан инфляцийг онилох мөнгөний бодлого (flexible inflation targeting)-ын гол зорилт юм.

Уламжлалт мөнгөний бодлогын нэг дутагдалтай тал нь санхүүгийн салбар дахь тэнцвэргүй байдал (imbalances)-ыг харгалзаж үздэггүй юм. Мөнгөний бодлогын шийдвэр гаргалтад гол үндэслэгээ болдог инфляци болон эдийн засгийн идэвхжил, мөчлөгийн төсөөлөл нь мөнгөний бодлогын шилжих механизм, эдийн засгийн төлөв байдал, зарим чухал эгзоген хувьсагчдын таамаглалд үндэслэсэн байдаг. Харин санхүү, зээлийн мөчлөг, хөрөнгийн үнийн өсөлт, санхүүгийн салбар дахь тэнцвэргүй байдал,

болзошгүй хөрөнгийн үнийн хөөсрөлт зэрэг санхүүгийн салбар дахь хүндрэлүүдийг илтгэх үзүүлэлтүүд нь инфляци болон эдийн засгийн идэвхжилд хэрхэн нөлөөлөх байдлаас нь харьцангуй хязгаарлагдмал хүрээнд авч үздэг. Санхүүгийн салбар дахь дээр дурдсан асуудлыг шийдэхэд дан ганц уламжлалт мөнгөний бодлого хангалтгүй бөгөөд түүнтэй харилцан уялдаа бүхий системийн эрсдэлийг бууруулахад чиглэсэн оновчтой микро болон макро зохистой бодлого шаардлагатай юм.

Хямралаас хойш инфляцийг онилох мөнгөний бодлогын хүрээнд хийгдэж буй өөрчлөлт

Институци	Макро эдийн засгийн зорилгын функц дахь хувьсагч	IT (1): Flexible Inflation targeting (Хямралаас өмнө)	IT (2): Flexible Inflation targeting (Хямралын дараа)	IIT: Integrated Inflation targeting (Хямралын дараа)
Мөнгөний бодлогын хороо	Inflation gap (I) Output gap (O)	Тайлорын дүрэм: I+O	Тайлорын дүрэм: I+O (FX)	Өргөтгөсөн шинэ дүрэм: I+O+C
Санхүүгийн тогтвортой байдлын институци	Credit gap (C)	Микро зохистой бодлогын хэрэгсэл (MiP)	Микро болон макро зохистой бодлогын хэрэгсэл (MiP + MaP)	Хоорондоо нийцтэй микро болон макро зохистой бодлогын хэрэгсэл (MiP + MaP)
Төв банкны интервенц	Exchange rate volatility (FX)	Цэвэр хөвөгч	Зохицуулалттай хөвөгч	Зохицуулалттай хөвөгч + зарим капитал контрол элемент

Эх сурвалж: “Inflation Targeting and Financial Stability: A Perspective from the Developing World” Agenor, Silva (2013).


Санхүүгийн системийн эрсдэлүүд болон макро зохистой бодлогын хэрэгслүүдийг цаг хугацааны (time dimension) болон системийн оролцооны (cross-sectional) гэсэн хоёр

хэсэгт ангилж үздэг. Цаг хугацааны санхүүгийн эрсдэлүүд нь санхүүгийн мөчлөг дагаж үүсдэг бол системийн оролцооны эрсдэл нь санхүүгийн зах зээл дэх төвлөрөл, зах зээлд оролцогчдын хоорондох хамаарлын зэргээс шалтгаалан үүсдэг. Системийн оролцооны эрсдэлийг микро болон макро зохистой бодлогын уялдаатайгаар түлхүү удирддаг бол цаг хугацааны эрсдэлийг мөнгөний бодлогын зорилтод нэгтгэх хандлага нэмэгдэж байна. Тухайлбал, уламжлалт мөнгөний бодлогын бүрэн ажил эрхлэлттэй үеийн үнийн тогтвортой байдлын зорилт дээр зээлийн идэвхжилийг оновчтой түвшинд нь барих зорилтыг нэмсэн мөнгөний бодлогын дүрмүүдийг санал болгож байна. Тухайлбал, хямралаас хойш уян хатан инфляцийг онилох мөнгөний бодлоготой санхүүгийн тогтвортой байдлыг зорилтыг хэрхэн уялдуулах талаар бий болж буй хандлагыг хүснэгт 1-т үзүүлэв.

Аливаа бодлогын зорилт амжилттай хэрэгжихийн урьдач нөхцөл нь түүний хэрэгжүүлэх институцийн оновчтой загвар юм. Тийм ч учраас санхүүгийн хямралаас хойш макро зохистой бодлого хэрэгжүүлэх институцийг бий болгож буй болон өмнө нь бий болсон загвараа эргэн харж буй орнуудын тоо өссөөр байна. Эдгээр реформын шинжтэй үйл явцад хоёр үндсэн хандлага ажиглагдаж байна. Зарим орны хувьд илүү нэгдмэл санхүүгийн институцийг бүрдүүлж байгаа бол нөгөө хэсэг нь засгийн газар эсхүл Төв банкаар толгойлуулсан санхүүгийн тогтвортой байдлын хороо (зөвлөл)—ийг бий болгох хандлагатай байна.



Банкны хянан шалгагч байгууллагууд



Эх сурвалж. BIS байгууллагын санхүүгийн салбарын институцийн түүвэр судалгаа (2011)

2011 онд ОУВС санхүүгийн салбарын институцийн чиглэлээр 50 улсыг хамруулан түүвэр судалгаа хийжээ. Нийт судалгаанд хамрагдсан 50 улсаас 31 нь, бүрэлдэж буй эдийн засагтай орнуудын хувьд гуравны хоёрынх нь хувьд Төв банк нь банкны хяналт шалгалтыг хариуцан хэрэгжүүлдэг байна. Бусад 19 орны хувьд төв банкнаас тусдаа буюу олон талт (multi-agency) бүтэцтэй байжээ. Харин төлбөрийн тооцооны систем буюу түүний хяналт шалгалт нь бүх орны хувьд үндсэндээ Төв банкны бүтцэд харьяалагддаг байна. Уламжлалт санхүүгийн системийн институци нь нэгдмэл буюу Төв банкиндаа дийлэнх нь нэгдсэн тохиолдолд илүү нэгдмэл санхүүгийн институцийг бий болгож байгаа бол санхүүгийн бодлогын дэд салбарууд олон институцид хуваагдсан бүтэцтэй буюу олон талт бүтэцтэй орнуудын хувьд санхүүгийн тогтвортой байдлын хороог байгуулах нь

түгээмэл бөгөөд тус хороо нь тодорхой хуулиар заасан үүрэггүй, шийдвэр гаргах эрх мэдэл нь бие даасан институциудад тархсан тохиолдолд илүү бодлого, институциудын уялдааг хангах зорилгоор ажилладаг байна.


СЭДЭВ 12:

МОНГОЛ УЛСЫН
ТӨЛБӨРИЙН
СИСТЕМ

Төлбөр гүйцэтгэгчээс төлбөр хүлээн авагчид мөнгөн хөрөнгийг шилжүүлэх үйл ажиллагаа, түүнийг зохицуулах, гүйцэтгэх эрх бүхий байгууллага, энэ үйл ажиллагаанд мөрдөх хууль тогтоомж, дүрэм, журам, гэрээ болон техник технологи бүхий дэд бүтэц, төлбөрийн хэрэгслийг бүхэлд нь хамарсан цогц нэгдлийг төлбөрийн систем гэж ойлгоно.

Ерөнхий бүтэц

“Төв банк (Монголбанк)–ны тухай хууль”–ийн 5.5, 8.2–т заасны дагуу Монголбанкны Ерөнхийлөгчийн 2006 оны 19 дүгээр тушаалаар банк хоорондын их, бага дүнтэй гүйлгээний дүнгийн хязгаарыг 1.0 сая төгрөгөөр тогтоосон бөгөөд 1.0 сая төгрөгөөс дээш буюу их дүнтэй төлбөр тооцоог “Банксүлжээ” системээр гүйцэтгэж байна. Бага дүнтэй төлбөр тооцооны систем болон картын төлбөр тооцооны системийг Үндэсний цахим гүйлгээний төв хариуцан төлбөр тооцоог 24/7 хуваариар буюу бодит цагийн горимоор дамжуулж байна.



Төлбөрийн систем дэх Монголбанкны үүрэг, оролцоо

Монголбанк нь төлбөрийн системийн үйл ажиллагаанд голлох үүрэг гүйцэтгэдэг ба үндэсний төлбөрийн системийн бодлогыг тодорхойлохын зэрэгцээ хяналт тавих, үнэлгээ хийх, шаардлагатай өөрчлөлтийг хийх замаар төлбөр тооцооны системүүдийн найдвартай, тасралтгүй, ажиллагаа, үр ашигтай байдлыг хангуулснаар мөнгөн тэмдэгтэд итгэх олон нийтийн итгэл, санхүүгийн тогтвортой байдалд дэмжлэг үзүүлдэг.

Монголбанкнаас төлбөрийн системийн найдвартай ажиллагааг хангах, харилцагчдын эрх ашгийг хамгаалах зорилгоор төлбөр тооцоонд шинээр нэвтэрч буй төлбөрийн хэрэгсэл, үйлчилгээг судлан дүгнэлт гаргаж, системийн оролцогч банкуудад холбогдох зөвшөөрлийг олгон, төлбөр тооцоог бодит цагийн горимоор, тасралтгүй дамжуулж байгаа эсэх, холбогдох журам, гэрээг мөрдөж байгаа эсэх, түүнчлэн өмнө шалгалтаар өгсөн үүрэг даалгаврыг биелүүлсэн эсэхэд хяналт тавьж, тогтмол шалгалт хийж байна.

Шимтгэл, цагийн хуваарь

Төлбөр тооцооны системүүдийн ажиллах цагийн хуваарь, дамжуулсан гүйлгээ тутмаас Монголбанкны авах шимтгэлийг дараах хүснэгтэд харуулав:

Төрөл	Ажлын Цаг	Монголбанкны авах шимтгэл
Бага дүнтэй гүйлгээ	24 цагаар	гүйлгээ бүрээс 180 төг
Их дүнтэй гүйлгээ	Ажлын өдрийн 9 – 17 цаг	гүйлгээ бүрээс 300 төг
Төлбөрийн карт ашиглан бэлэн мөнгө авах гүйлгээ	24 цагаар	гүйлгээ бүрээс 40 төг
Төлбөрийн картын үлдэгдэл шалгах гүйлгээ	24 цагаар	гүйлгээ бүрээс 10 төг

Төрөл	Ажлын Цаг	Монголбанкны авах шимтгэл
Төлбөрийн карт ашиглан худалдан авалт хийх гүйлгээ	24 цагаар	3000 төгрөг ба түүнээс их дүнтэй гүйлгээ бүрээс 20 төгрөг 3000 төгрөгөөс бага дүнтэй гүйлгээ бүрээс 1 төгрөг

Эх сурвалж: Монголбанк

Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар “Монголбанкны үйлчилгээний шимтгэлийн ерөнхий нөхцөл”-ийг жил болгон шинэчлэн баталж, мөрддөг. Энэ үйлчилгээний шимтгэлийн нөхцөлд зөвхөн төлбөрийн системийн оролцогч банкуудаас Монголбанкны авах шимтгэлийг тусгасан байдаг ба харилцагчаас авах шимтгэлийг “Банкны тухай хууль”-д заасны дагуу төлбөр тооцооны үйлчилгээний үзүүлж байгаа банк нь өөрөө тогтоодог.

Банкны оролцоо

Банк нь төлбөрийн системийн үндсэн буюу шууд оролцогч бөгөөд харилцагч байгууллага, иргэдийн бэлэн болон бэлэн бус төлбөр тооцоог гүйцэтгэх эрх бүхий байгууллага юм.

Банкууд нь хуулийн этгээд, иргэдээс харилцах, хадгаламж татан төвлөрүүлж, зээл, төлбөр тооцооны үйлчилгээг үзүүлдэг. Монгол Улсад 2014 оны жилийн эцсийн байдлаар 14 банк 200 салбар, 1136 тооцооны төв, 148 тооцооны касстайгаар үйл ажиллагаа явуулж байна. Дотоодын санхүүгийн зах зээлд нийт 1484 банкны нэгж үйл ажиллагаа явуулж байгаагийн 1131 нь хөдөө орон нутагт байна.

Тоо баримт

Монголбанкнаас бэлэн бус төлбөрийн хэрэгслийг дэмжих бодлого баримталсны үр дүнд төлбөрийн картын хэрэглээ жилээс жилд хурдацтайгаар нэмэгдэж байна.

Одоогийн байдлаар Монголбанкнаас 11 банк төлбөрийн картын үйл ажиллагааны зөвшөөрөл авч, үйлчилгээг үзүүлж байгаагаас ХААН банк, Худалдаа хөгжлийн банк, Голомт банк, Төрийн банк, Хас банк нь төлбөрийн картын нэгдсэн сүлжээ буюу картын төлбөр тооцооны системд шууд холбогдсон үлдсэн оролцогч бөгөөд бусад 6 банк нь дэд гишүүн байдлаар шууд бусаар холбогдон, карт эзэмшигчийн төлбөр тооцоог гүйцэтгэж байна.

Төлбөрийн картын хэрэглээ, төхөөрөмж, гүйлгээний талаар тоо баримт дурдвал:

Гүйлгээний дүн тэрбум төгрөгөөр, тоо сая ширхгээр

Карт хэрэглэгчийн тоо	2014 он, II улирал	2015 он, II улирал		Өөрчлөлт (%)
		Нийт	Орон нутаг	
Карт эзэмшигч	3 450 935	3 757 729	1 074 181	8.9
Карт идэвхтэй ашиглагч	1 330 306	1 835 474	500 183	38.0
Төхөөрөмжийн тоо	2014 он, II улирал	2015 он, II улирал		Өөрчлөлт (%)
		Нийт	Орон нутаг	
ПОС	9 977	14 018	3 113	40.5
МПОС	1 351	3 083	49	128.2
ПОБ	2 506	1 836	1 005	-26.7
АТМ	1 101	1 277	295	16.0
Бусад	–	29	–	–

Гүйлгээ		2014 он, II улирал	2015 он, II улирал		Өөрчлөлт (%)
			Нийт	Орон нутаг	
ПОС	Дүн	303.3	400.8	42.8	32.1
	Тоо	7.3	9.6	1.8	31.3
МПОС	Дүн	–	1.3	–	–
	Тоо	–	0.05	–	–
ПОБ	Дүн	255.1	52.3	9.4	–79.5
	Тоо	0.5	0.3	0.01	–37.7
АТМ	Дүн	2 141.5	1681.7	289.6	–21.5
	Тоо	25.0	37.0	7.6	48
Нийт	Дүн	2 699.8	2 136.1	341.8	–20.9
	Тоо	32.9	47.0	9.41	42.7

Эх сурвалж: Монголбанк. Дэлгэрэнгүй тоо, мэдээг Монголбанкны цахим хуудаснаас авах боломжтой.

СЭДЭВ 13:

МОНГОЛБАНКНЫ

АЛТ

ХУДАЛДАН АВАЛТ

МОНГОЛБАНК ЯМАР ЗОРИЛГООР АЛТ ХУДАЛДАН АВДАГ ВЭ?

Гадаад валютын улсын албан нөөцийг нэмэгдүүлэх дотоодын эх үүсвэрүүдийн нэг нь алт худалдан авалт юм.

Монголбанк дотоодын алт олборлогч аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс худалдан авсан алтыг гадаадын байгууллагуудад олон улсын жишигт хүргэн цэвэршүүлэн мөнгөжүүлж, гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлдэг.



МОНГОЛБАНКНЫ АЛТ ХУДАЛДАН АВАЛТЫН СТАТИСТИК ХЭДЭД ХҮРСЭН БЭ?

2014 онд Монголбанк 79 аж ахуйн нэгж, 105 иргэнээс нийт 12.7 тонн алтыг 830.8 тэрбум төгрөгөөр худалдан авсан нь өмнөх оноос 6.7 тонн буюу 2 дахин өссөн үзүүлэлт юм.

Монголбанкны Эрдэнэсийн санд 2015 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар 2,018.6 кг алтны үлдэгдэлтэй байсан ба 2015 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Монголбанк давхардсан тоогоор 1587 аж ахуйн нэгж байгууллага, 1723 иргэнээс нийт бохир жингээр 12,870.7 кг алт худалдан авсан байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 20 хувиар өссөн тооцоо гарч байна.



МОНГОЛБАНКНЫ АЛТ ХУДАЛДАН АВАЛТ НЭМЭГДСЭН ШАЛТГААН ЮУ ВЭ?

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулан “Монголбанк түүнээс эрх олгосон банкинд худалдсан алтанд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хэмжээг 2.5 хувь, нэмэлт төлбөрийн хэмжээг 0 хувьтай тэнцүү” байхаар зааж 2014 оны 01 дүгээс сарын 24-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж байна. Уг өөрчлөлт орсонтой холбоотойгоор Монголбанкинд иргэдийн тушааж буй алтны хэмжээ эрс өссөн.




АЖ АХУЙН НЭГЖ НИЙТ АЛТ ТУШААЛТЫН ХЭДЭН ХУВИЙГ ЭЗЭЛЖ БАЙНА ВЭ?

2015 оны эхний 10 сарын байдлаар нийт худалдан авсан алтны 53.8 хувийг буюу 6,925.1 кг алтыг аж ахуйн нэгж, байгууллагаас, үлдсэн 46.2 хувь буюу 5,945.6 кг алтыг иргэдээс худалдан авсан байна.



2015 ОНД ХУДАЛДАН АВСАН АЛТНЫ ХЭМЖЭЭ ГАДААД ВАЛЮТЫН НӨӨЦИЙН ЯМАР ХЭСГИЙГ БҮРДҮҮЛСЭН БЭ?

2015 онд 12 удаагийн ачилтаар нийт бохир жингээр 10,9 тонн (цэвэр жингээр 289.1 мянган унци) алтыг экспортлосон байна. Энэ нь 2015 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн ханшаар тооцоход ойролцоогоор 311.1 сая ам.доллараар валютын нөөцийг бүрдүүлсэн тооцоо гарч байна.



Эх сурвалж: Монголбанк

СЭДЭВ 14:

МӨНГӨН
ТЭМДЭГТИЙН
НУУЦЛАЛ

ХОРИН МЯНГАН ТӨГРӨГИЙН ДЭВСГЭРТ



Тайлбар:

Анх хэвлүүлсэн он: 2006

Хэмжээ (мм): 72х150

Үндсэн өнгө: Ногоон

Нүүрэн талын зураг: Чингис хааны хөрөг

Ар талын зураг: Төрийн есөн хөлт цагаан туг

Нууцлал:

1. Тусгай гэрлээр харахад Чингис хааны хөрөг гэрэлтэн тодорно.
2. Холограмм дардас дотор Соёмбо, 20000–тын тоо солонгорч үзэгдэнэ.
3. Дэвсгэртийн дэвсгэр зураг, ялангуяа 20000 гэсэн нэрлэсэн үнэ нь гарт мэдэгдэхээр товгор хийгдсэн.
4. Дэвсгэр зургийн зүүн доод талын босоо хэвтээ ирмэгийн дагуу "MONGOLBANK" гэсэн үгийг маш жижгээр бичсэн.
5. Гэрлийн эсрэг барьж харахад Чингис Хааны хөрөг, "МОНГОЛБАНК" гэсэн үгийн товчлол болох "МБ" үсгүүд усан хээгээр тодорч харагдана.
6. Налуугаас харахад дөрвөн морьтон баатрын дүрс, дэвсгэр өнгө нь дөрвөн хэсэгт тодорч үзэгдэнэ.
7. Гурван мм–ийн өргөнтэй тасалдаж харагдах металл утсан дээр "MONGOLBANK" гэсэн үг болон Соёмбо солигдож харагдана.
8. Гэрлийн эсрэг барьж харахад дэвсгэртийн хоёр талд байрлах дугуй дүрс зөрүүгүй давхцана
9. Тусгай гэрлээр харахад дэвсгэрт металл ялтсан ширхэгтэй харагдана.

АРВАН МЯНГАН ТӨГРӨГИЙН ДЭВСГЭРТ



Тайлбар:

Анх хэвлүүлсэн он: 1995

Хэмжээ (мм): 72x150

Үндсэн өнгө: Улбар шар ба ногоон

Нүүрэн талын зураг: Чингис хааны хөрөг

Ар талын зураг: Эртний Хархорин хотын дотоод талбайн дүрс

Нууцлал:

1. Металл утас
2. Серийн дугаар 2 үсэг 7 тоотой 2 өнгөтэй нэг нь хэт ягаан гэрлээр шарахад гэрэлтэнэ.
3. Усан хээгээр бүтээсэн Чингис хааны хөрөг.
4. Зуйван дугуй дотор гэрлийн ойлтод морь унаж сэлэм барьсан баатрын дүрс болон дэвсгэртийн үнэ солигдож үзэгдэнэ.
5. Ар өврийн бүх талбайн хээ угалзад офсет скайнер, фото хувилагчийн эсрэг хийц хийсэн.
6. Хэт ягаан туяанд гэрэлтэнэ.
7. Нүдэнд үл үзэгдэх бичил үсгэн шугаманд “Mongol Bank” гэсэн бичиг гарна.
8. Үндсэн хээ, тоо үсгүүдийг гарт тэмтрэгдэхээр товгор хэвлэсэн.
9. Хэт ягаан гэрлээр шарахад дэвсгэртийн үнэ 10000 гэж тодорно.
10. Дэвсгэртийн 2 талд байгаа дугуй дүрс заавал давхцаж харагдана.

ТАВАН МЯНГАН ТӨГРӨГИЙН ДЭВСГЭРТ



Тайлбар:

Анх хэвлүүлсэн он: 1994

Гүйлгээнд гарсан он: 1995

Хэмжээ (мм): 72x150

Үндсэн өнгө: Улбар улаан

Нүүрэн талын зураг: Чингис хааны хөрөг

Ар талын зураг: Эртний Хархорин хотын дотоод талбайн дүрс

Нууцлал:

1. Металл утас
2. Серийн дугаар нь хэт ягаан гэрлээр шарахад гэрэлтэнэ.
3. Усан хээгээр бүтээсэн Чингис хааны хөрөг
4. Зуйван дугуй дотор гэрлийн ойлтод морь унаж сэлэм барьсан баатрын дүрс болон дэвсгэртийн үнэ солигдож үзэгдэнэ.
5. Ар өврийн бүх талбайн хээ угалзад офсет скайнер, фото хувилагчийн эсрэг хийц хийсэн.
6. Хэт ягаан туяанд гэрэлтэнэ.
7. Нүдэнд үл үзэгдэх бичил үсгэн шугамд “MongolBank” гэсэн бичиг гарна.
8. Үндсэн хээ, тоо үсгүүдийг гарт тэмтрэгдэхээр товгор хэвлэсэн.
9. Хэт ягаан гэрлээр шарахад дэвсгэртийн үнэ 5000 гэж тодорно.
10. Дэвсгэртийн 2 талд байгаа дугуй дүрс заавал давхцаж харагдана.

МЯНГАН ТӨГРӨГИЙН ДЭВСГЭРТ



Тайлбар:

Анх хэвлүүлсэн он: 1993

Хэмжээ (мм): 72x150

Үндсэн өнгө: Хөх

Нүүрэн талын зураг: Чингис хааны хөрөг

Ар талын зураг: Гэр тэрэг

Нууцлал:

1. Чингис хааны зураг бүхий усан хээ
2. Тасалдаж харагдах нууцлалын утас
3. Бичил үг
4. Хэвлэгчийн эсрэг бүтэц
5. Давхцаж харагдах хээ
6. Товгор хэвлэл
7. Фосфорт гэрэлтэж харагдах бүтэц
8. Фосфорын ялгарч харагдах серийн дугаар
9. Гарын үсэг

ТАВАН ЗУУН ТӨГРӨГИЙН ДЭВСГЭРТ



Тайлбар:

Анх хэвлүүлсэн он: 1993

Хэмжээ (мм): 70x145

Үндсэн өнгө: Шар ногоон ба шар хүрэн
Нүүрэн талын зураг: Чингис хааны хөрөг
Ар талын зураг: Гэр тэрэг

Нууцлал :

1. Чингис хааны зураг бүхий усан хээ
2. Тасалдаж харагдах нууцлалын утас
3. Бичил үг
4. Хэвлэгчийн эсрэг бүтэц
5. Давхцаж харагдах хээ
6. Товгор хэвлэл
7. Фосфорт гэрэлтэж харагдах бүтэц
8. Фосфорын ялгарч харагдах серийн дугаар
9. Гарын үсэг

ЗУУН ТӨГРӨГИЙН ДЭВСГЭРТ



Тайлбар:

Анх хэвлүүлсэн он: 1993

Хэмжээ (мм): 68x140

Үндсэн өнгө: Ягаан хүрэн

Нүүрэн талын зураг: Сүхбаатарын хөрөг

Ар талын зураг: Адуун сүрэг

Нууцлал:

1. Сүхбаатар жанжны зураг бүхий усан хээ
2. Нууцлалын утас бичил үг
3. Хэвлэгчийн эсрэг бүтэц
4. Давхцаж харагдах хээ
5. Товгор хэвлэл
6. Фосфорт гэрэлтэж харагдах бүтэц
7. Фосфорын ялгарч харагдах серийн дугаар
8. Гарын үсэг

ТАВИН ТӨГРӨГИЙН ДЭВСГЭРТ



Тайлбар:

Анх хэвлүүлсэн он: 1993

Хэмжээ (мм): 66x135

Үндсэн өнгө: Хүрэн

Нүүрэн талын зураг: Сүхбаатарын хөрөг

Ар талын зураг: Адуун сүрэг

ХОРИН ТӨГРӨГИЙН ДЭВСГЭРТ



Тайлбар:

Анх хэвлүүлсэн он: 1993

Хэмжээ (мм): 64x130

Үндсэн өнгө: Хар улаан

Зураг: Сүхбаатарын хөрөг

Ар талын зураг: Адуун сүрэг

АРВАН ТӨГРӨГИЙН ДЭВСГЭРТ



Тайлбар:

Анх хэвлүүлсэн он: 1993

Хэмжээ (мм): 61x125

Үндсэн өнгө: Хар ногоон

Зураг: Сүхбаатарын хөрөг

Ар талын зураг: Адуун сүрэг

ТАВАН ТӨГРӨГИЙН ДЭВСГЭРТ



Тайлбар:

Анх хэвлүүлсэн он: 1993

Хэмжээ (мм): 59x120

Үндсэн өнгө: Тод улаан

Зураг: Сүхбаатарын хөрөг

Ар талын зураг: Адуун сүрэг

НЭГ ТӨГРӨГИЙН ДЭВСГЭРТ



Тайлбар:

Анх хэвлүүлсэн он: 1993

Хэмжээ (мм): 57x115

Үндсэн өнгө: Тод хүрэн

Нүүрэн талын зураг: Арслан

Ар талын зураг: Соёмбо

- Монголбанк. (2013). *Монгол Улсын санхүүгийн тогтвортой байдлын тайлан*. Дугаар 1, Admon.
- Монголбанк. (2014). *Монгол Улсын санхүүгийн тогтвортой байдлын тайлан*. Дугаар 3, Admon.
- Монголбанк. (2010). *Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн ажиллах дүрэм*.
- Монголбанк. (2012). *Монголбанкны ерөнхийлөгчийн тушаал*. Дугаар А–69.
- BIS. (2012). *Characterising the financial cycle: Don't lose sight of medium term!*. BIS Working Papers No 380.
- IMF. (2012). *Financial stability reports: What are they good for?*. WP/12/1, Washington.
- IMF. (2011). *Macroprudential policy: An organizing framework*. Washington.
- IMF. (2011). *Macroprudential policy: What instruments and how to use them?*. WP/11/238, Washington.
- IMF. (2014). *Annual Report on Exchange Arrangements and Exchange Restrictions*. Washington.
- Mishkin, F. (2004). *The economics of money, banking, and financial markets*. 7th edition, Prentice Hall.
- Robert Shiller (2011). *Banks, Lecture 13*, Yale University, online.yale.edu
- World Bank. (2012). *Benchmarking financial systems around the world*. Policy Research Working Paper, WPS6175.

This image shows a single sheet of white paper with horizontal ruling lines. The lines are evenly spaced and run across the width of the page. There are no margins, text, or other markings on the paper.

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

МОНГОЛБАНК ОЛОН НИЙТИЙН БОЛОВСРОЛ, МЭДЭЭЛЛИЙН ТӨВ

Мэдээллийн албаны утас: 11312939

Боловсролын албаны утас: 11310081

E-mail: info@mongolbank.mn

<https://www.facebook.com/Mongolbank.mn/>

https://twitter.com/Mongolbank_mn